


Ч.ГАЛСАН

АЯНГАТ ЦАГИЙН ТУУЖ



Аянгат цагийн тууж

Эрхлэн гаргасан: Болор судар хэвлэлийн газар

Зохиолч: Ч.Галсан

Редактор: Д.Амарзаяа

Хэвлэлийн эхийг: Б.Хуяг

ISBN: 978-99929-1-711-3

© Энэхүү бүтээлийн эрх нь Монгол Улсын Зохиогчийн Эрхийн тухай хуулиар хамгаалагдсан болно. Бүтээлийг цахим хэлбэрээр түгээх эрхийг bookstore.mn цахим хуудас эзэмших бөгөөд зөвшөөрөлгүйгээр бүтнээр нь буюу хэсэгчлэн хувилах болон бусад ямар нэгэн хэлбэрээр олшруулах, ашиглахыг хориглоно.

Өмнөтгөл

Эзэнт гүрний монголчуудын их байлдан дагууллын нэлэнхүй хэрэгцээ болж асан хөтөлгөө морь яах аргагүй математикийн шинжлэх ухааны орчин үеийн шинэхэн салбарын нэг найдварын онолын эх үндсэн санаа байсан гэхэд хилсдэх юун.

өнөөдөр хос морины сойлыг аль алийг нь тэгш тааруулан холын Герман, Европт орон улсаа алдаршуулж, олон зууны их өв, өндөр соёлтой уншигчдад нь өндөр үнэлэгдсэн зохиолоо бичиж туурвиж байгаа Чинагийн Галсан гуай Их эзэнт гүрний хөтөлгөө морьгнуудаас хойш их дэлхийд дахин туурайн мөрөө дурайтал гаргах гэсэн бидний итгэл найдварын онол -ын нэг эзэн нь болж байна.

Салсан өдөр байхад уулзах өдөр бий хэмээн Аянгат цаг -ийн Жанибек гуай хэлдэг. Чинагийн Галсан гуайтай холын холыг зорин хөтөлгөө морьтой хурдалж явахад нь уулзах өдөр олон олон бий гэдэгт эргэлзэхгүй байна. Энэ удаа Мөнхийн үсэг -ийнхэн бид зохиолч Чинагийн Галсан гуайг та бүхэнтэй уулзуулж байгаагаа их аз завшаан хэмээн тод дуугаар тэмдэглэж, том үсгээр бичиж байна.

Цөвүүн цаг дор Жанибек өвгөний үнэнч шударга, цайлган цагаан сэтгэл, ухаалаг зан чанар муу муухайг Аянга адил цахилж, цэвэрлэх болтугай

Цоодолын Жаргалсайхан

Бүтээлийн хос морьтон

“БНМАУ дахь үндэсний цөөнх ту ва гаралтай залуугийн герман хэлээр бичсэн зохиолууд нь хэл яруу, өнгө аяс уянгалаг бөгөөд тэдгээрт... ну таг усныхныхаа хувь заяаны тухай өгүүлнэ” гэсэн сонин мэдээг БНАГУ-ын “Мэдээллийн алба” 1980 онд зарлан түгээжээ.

Хүмүүс тэр мэдээг уншаад уул но мыг хэзээ гарахыг сураглан хүлээж байжээ. Учир нь монгол хүн герман хэлээр зохиол бичсэн тухай урьд өмнө сураг гардаггүй байжээ.

Удсан ч үгүй Монгол ардын ху вьс галын 60 жилийн ойн 1981 онд БНАГУ-ын номын дэлгүүрүүдэд “Чина гийн Галсан “Аянгат цагийн тууж” бо лон бусад тууж, өгүүллэг, төгсгөлийн үгийг бичсэн Эрвин Штриттматтер, Фольк, Вельт хэвлэлийн газар Берлин. 1981 он” гэсэн 224 хуудастай ном уншигчдын гар дээр очжээ.

-“Зохиолын яруу хэл, гүнзгий сэт гэлгээ сэтгэлийг минь булаав” гэж Ард чилсан Германы уншигч Клаус Омихен “Нойес Дойчланд” сонинд удалгүй бичив.

“Сэтгэлийг минь энүүн шиг хөдөл гөсөн номыг хамгийн сүүлд хэдийд уншсанаа санахгүй байна! Өөр соёл, хэл бүхий ертөнцөөс гаралтай, герман хэлийг ердөө аравхан жилийн өмнө сурч эхэлсэн тэр хүн тэр хэлээр ийм ном биччихлээ гэж бодоход сэтгэлд даанч багтаж өгөхгүй байна” гэж баруун германы уншигч Е.А.Толле гэгч гайхан бичжээ” (Нийдерзаксен).

Ийнхүү “Зексише Цайтунг”, “Нойе Дойче литератур”, “Зоннтаг”, “Тюрин гер Ландесцайтунг” зэрэг сонин, сэт гүүлүүдэд Чинагийн Галсангийн но мын тухай захидал, шүүмж хойно хойноосоо цувран гарч эхэлжээ. Тэд ний гол утга санаа нь ижил байлаа.

“Орон улс яруу найрагчаа төрүүлж, яруу найрагч орон улсаа алдар шуул даг” хэмээн Ардчилсан Германы нэрт зохиолч Эрвин Штриттматтер Ч.Галсангийн номд бичсэн төгсгөлийн үгэндээ цохон хэлжээ. Үнэхээр, хувьсгалын өмнөх Монголын хоцрогдсон бөглүү хязгаар байсан Алтай нутгийн бага ястны дотроос дэлхийн утга зохиолын сонгодог суу билэгтэн Гёте, Хайне, Шиллерийн эх хэлээр, тэдний аугаа их өв уламжлалаар амташсан гоо сайхны өндөр соёлтой уншигчдад таалагдан үнэ лэгдэх зохиол бүтээх залуу авьяастныг төрүүлж гаргасан нь манай со циалист эх орны эрчимтэй хөгжил, хүн ардын соёлжилтын хурд далайцын бас нэгэн бахархалтай жишээ юм. Орон улсаа алдаршуулах чансаатай бүтээл туурвих нь уран бүтээлчийн гэрэлт мөрөөдөл мөн.

Чинагийн Галсангийн германаар бичсэн зохиолууд социалист байгуу лалтын явцад өсч бойжсон монголын залуучуудын авьяас билгийг илтгэн харуулаад зогсохгүй, дэлхийн соёлын өндөр оргил өөд тэдний цуцалтгүй тэмүүлэн мацаж яваагийн бахархал, үндэсний хэлбэртэй, социалист агуул гатай интернационалч соёлын цоо шинэ эрдэнэсийг эрх жаргалант мон голчууд урлаж бүтээж байгаагийн нэ гэн өвөрмөц сонин баримт юм. “Хэр гийн учир ямар хэлээр бичсэнд биш, харин маш сайн бичсэнд л байгаа юм. Биднийг харь хол ертөнцийн түм буман жижиг сажиг зүйлд төөрүүлж самгардуулахгүйгээр зохиолч цөөхөн, оносон, туйлдаа хүртэл цэнэгшсэн үгээр монгол эх орныхоо өнгөрсөн, ирээдүйн тухай цээжиндээ тээж явдаг бодлоо зураг болгон амилуулж байна. Тэрээр нурших дургүй шигээ бас ят гах дургүй, гагцхүү түүний хэлсэн бүгд нь сэтгэлийн үзүүрт сэрхийтэл хүрч, нүдэнд харагдаж, чихэнд дуул даж,

хамарт сэнгэнэж байх шиг санаг дана” гэж доктор Ирмтрауд Гучке “Нойес Дойчланд” сонинд гаргасан шүүмжиндээ Галсангийн уран бүтээлийг үнэлэн бичжээ.

Чинагийн Галсангийн зохиолуудын онцлог нь цөөн үгээр, товч тодорхой дүрсэлдэгт байна гэдгийг европын уншигчид дурдсан сонин сэтгүүлүүдэд цохон тэмдэглэсэн байна. Галсангийн бүтээлийн өөр нэг онцлог гэвэл гол төлөв ёс суртахууны хурц асуудлыг өргөн хүрээтэй, гүнзгий агуул гатай дүрслэн харуулж, учир шалт гааны нарийн холбоонд нь итгэл үнэмшилтэйгээр зурах урлаг юм. Ялангуяа “Аянгат цагийн тууж”-д гар даг Жанибек өвгөний дүр үнэнч шу дарга, цайлган цагаан сэтгэлтэй, ухаа лаг хүний дотоод ертөнцийг цөөн үгээр маш тод томруун нээж харуулсан мартагдашгүй зураг болж хүний ой ухаанд хоногших юм. Өвгөн тэмээчний туулж өнгөрүүлсэн эгэл бус амьдралын ээдрээтэй бөгөөд баяр, гуниг хосолсон өнгө аясыг Галсан маш чадварлагаар дэлгэн харуулж чаджээ. Хэл яриа нь бодол санааныхаа нарийн ширийнийг үнэмшигдмээр хурц илэрхийлж чадаж байна. Нийтийн үйлсийн төлөө зүтгэсээр хувийн амьдралаа хайхарсангүй явж хал үзэж, халуун чулуу долоосон Жанибекийн дүр бол зохиолчийн ололт төдийгүй, манай уран зохиолд бий болсон шинэ зүйл мөн. Чинагийн Галсангийн бүтээлд манай эх орны баруун хязгаарын бага ястнуудын амьдрал ахуйн онцлогийг урьд өмнө уран зохиолд төдий л дүрсэлж амжаагүй байсан талаас нь зурж үзүүлсний хувьд үнэ цэнэтэй зүйл элбэг байна. “Уул тал, ургамал амьтан, нүүдэлчид, жингийн тэмээ, машины цуваа, орчин үеийн өндөр харш, эсгий гэр, үйлдвэрлэлийн цоо шинэ болон балар эртний арга ухаан бүгдээр энэ хүү хурц зөрчил, уянгын аясын аль алиныг агуулсан номонд байраа эзэлжээ” гэж “Националь Цайтунг” сонинд Эрих Феттер бичжээ.

Галсан эх орондоо хайртай сэтгэлээ Алтай Таван Богдын цаст цагаан оргил, түүний сүрлэг дүрийг тольдон байдаг Хар нуурын тухай бичсэн уянгалаг үгсээрээ яруу тод дүрслэн гаргажээ. Галсан зохиол бүтээлээ эх лээд герман хэлээр бичиж, дараа нь түүнээсээ монголд орчуулдаг байна. Ингэсэн нь ч зарим зохиолоос нь мэдэгдэж байна. Гэвч сүүлийн үед шууд монголоороо бичсэн нилээд зохиол гаргаж, бүтээлийнхээ хос мори ны сойлгыг аль алийг нь тэгшээр тааруулж байгааг ялангуяа “Хөдөлмөр” сонинд Галсангийн бичиж нийтлүүлж байгаа нийтлэл, сурвалжлага, өгүүлэл тэмдэглэлээс харахад илэрхий байна.

Уран зохиолын ертөнцөд өвөрмөц дүр, хэллэг бүхий сонин зохиолоо герман, монгол хэлээр бичиж уран зохиолд орж ирсэн авьяаслаг зохиолч, сэтгүүлч Чинагийн Галсан уран сайхны орчлонд олон өртөө газар сульдахгүй хол аялах нь дамжиггүй. Учир нь гэвэл тэр сэлгээ морьтой ажээ. Нэг мориороо европын сонгодог соёлын хязгааргүй ертөнцөд, нөгөө мориороо дорнын соёлын нүд алдрам өргөн талд хатируулан явж, холыг туулж, ихийг бүтээхийг түүнд хүсэн ерөөж байна.

Л.Түдэв

Аянгат цагийн тууж

Гол, шугуй ард хоцорч, тал эхэл лээ. Ус нь татраагүй голоор шумбуулан гарсан нойтон би еэ буман шумуулд хучуулсан морьд сэмэр хий бүтээлэг нөмөрсөн мэт харагдана. Адгуус сүү лээрээ, бид гараараа зогсоо зайгүй ширвэвч шу муулан үүл эс сийрэгших нь одой дээрэмчдийн өлөн амьдрахын орон д цадаж үхэхээр шийд сэнийг илтгэх бөлгөө.

Халуун өдөр болох төлөвтэй, тэн гэрийн зүүн хаяа өөд дөнгөж авирч эхэлсэн нар ар нуруунаас гал мэт төө нөх тул морьдын нойтон биес төдөлгүй хатсан бо ловч амьд үлдсэн шумуулын шавх руу салахгүй дагасаар, одоо түрүүчийнх шиг зэгэл цайвар биш, бараг улайран ягааран харагдана.

Шатаах нь шив дээ гэж намайг хэлбэл цуг яваа нөхөр минь болох нэгдлийн тэмээчин өв гөн “Гайгүй ч биз. Харин ч аадар асгаж, араас нь цас орж байх вий” гэлээ.

Би гайхан эргэж харахдаа нар тэн гэрийн хаяа хоёрын завсар асар том бөмбөлгийн орой шиг зэгэл үүл ний мөлгөр сэжүүр цухуйн байхыг олж ажиглалаа. Тэнгэрийн тэрхэн тол боноос бу сад хэсэг нь номин цэнхэр туяа цацруулсан бо лор толь мэт цэв цэлийнэ. Үдийн алдад бороо орж мэдэх юм шүү гэж бодлоо. Энэ бодол сэт гэлд минь бяцхан түгшүүр сэ рээн, тэр түгшүүр намдаж өгөлгүй, яван явсаар аян замын минь нөхрийн тухай бодол болж хувирав бололтой. Хүн амьтан энэ өвгөнөөс яагаад л нэг хулгаад байдаг юм бол? Түүнтэй чонын авд мордох болсныг минь дуулахдаа “Тэр Жанибектай цуг чамайг буу үүрүүлээд эзгүй хөдөө хээр явуулж байх юм болж байна уу?” гэж ээж минь хангинаад өөр нэгнийг олж гурвуул болоод явна гэж амласан хойно минь сая л намдасныг нь яана. Гэтэл чононоос өөр юу ч аг нахыг эс зөвшөөрдөг зургадугаар сар ч шувтраагүй ийм үед бидэнд хань болчих хүн олдсонгүй. Бодвол тэ мээ чин хөгшнийг араатан чоно авлах ча дал тай гэж итгэх амьтан надаас өөр даанч байгаагүй юм байлгүй.

Жанибек бол нилээн дээр үед хэнд ч гэм хор хүргэлгүй замаараа явсан оргодлын амийг бүрэлгэсэн этгээд гэ сэн шивэр авир яриа байдгийг би мэднэ. Энэ цуу яриаг эсэргүүцэгчид өнөөх амь хохирогчийг өвч зэвсэг тэйгээ цэр гэс оргосон олиггүй этгээд байсан, түүнийг баривчлах үүрэг Жанибект оногдсон, тэгээд буудалцаан гарсан үеэр цаадах нь суманд өртсөн гэнэ. Тэгэхдээ Жанибек ганцаараа ч биш, зөндөө олон хүн цуг явалцсан, тэр дунд шөнийн цаг байсан тул өнөөх сум чухам хэний буунаас гарсныг мэдэхийн аргагүй гэцгээнэ.

Бас Жанибекийг эхлээд ардын багш, дараа нь сумын дарга, бүр хо жим намын үүрийн дарга байсан гэж ярилцана. Тэр ч байтугай зарим нь түүнийг “нөхөр багшаа”, аль эсвэл “нө хөр даргаа” гэж дуудах бөгөөд үүний цаана заримдаа тохуурхал, заримдаа ч бүр дайсагнал нуугдаж байх мэт сонсдоно. Харин миний л мэдэх хо риод жилд нэгдлийн тэмээ дагасан хүн. Түүнийг жилд нэгээс илүү удаа харж байснаа би санахгүй байна. Огт харалгүй өнгөрүүлсэн жил ч бий байх. Үүнд нь би гайхаж байсангүй. Учир нь өвөл зунгүй хоштой, айл амьтан тэр болгон хүрэхгүй аглаг зэлүүд нутгаар сүргээ хариулж явдаг зориг тэвчээртэн малчин удамтны дунд олон бий. Бас үрээ танихгүй өнөр өтгөний хажуугаар сүүдрээ бараадсан өнчид байдаг нь энэ орчлонгийн, бидний нэг хэсэгтээ л эвлэрэхээс аргагүй үнэ ний нэг тул тэмээчин өвгөний ганц бие аж төрөн явдагт нь гайхахаар юм бүр ч байсангүй.

Би дотроо Жанибекийн талд орж, зарим хү мүүсийн амнаас түүнийг өөлж баалсан аястай гардаг үгийг нийгмийн эрх ашгийг тууштай хамгаалсаар яваад зөндөө олон дайсантай бол чихдог сайн хүмүүст тохиолддог шу дар га бус явдлын л нэг гэж үздэг билээ. Хувьсгалт эргэлт, хувьсгалын эсрэг үймээн дайн гачигдлын бэрх үед шинэ нийгмийг хамгийн хатуу нударгаар хамгаалах учиртай байсан нь ойлгомжтой. Нөгөө хүн амины хэргийн тухайд гэвэл эхнээсээ эцэс хүртэл үндэсгүй хардлага бөгөөд, үхлийн сум нээрээ л түүний буунаас гарсан байлаа ч гэсэн, тэр ч атугай, бүр гэгээн цагаан өдөр эргэлзээгүй гэрчийн нүдний өмнө онилж байгаад буудсан байлаа ч гэсэн шаардлагат үүргээ л биелүүлсэн нь тэр биз. Учир нь цаадах нь эх орон аюулд учраад байсан цаг үед тангарагт албанаасаа няцсан зэвсэгт оргодол билээ.

Гагцхүү Жанибекийг ажиглаад бай вал бусдын шивэр авир яриа надад падгүй гэсэн байдалтай харагдана. Тэрбээр түрүүлж ам нээх гэж үгүй байтлаа нэг л яриад эхэлсэн бол зогсохыг үл мэднэ. Тэр нь их төлөв өнөөх л тэмээнийхээ тухай яриа байх бөгөөд энэхүү зарим хүмүүсийн зожиг, халуун говийн тэнүүлчин гэж нүд үзүүрлэдэг адгууст бүр амин голоосоо хайртай болсон нь дууных нь өнгөнөөс л мэдэгдэнэ. Энэ чанарыг нь миний бие хэд хоногийн өмнө үдэш шөнийн цагаар мэдэхгүй замд төөрч будилж яваад тэмээчний хош дээрээс бууж тэнд хоносноос нааш мэддэг болсон юм. Тэр шөнө өвгөн тэмээ малын хажуугаар бас чоно нохой, ан авын талаар тун дур татам ярьсан тул өглөө нь би тэсэлгүй намайг чонын авд дагуулж явахыг түүнээс аминчлан гуйсан билээ.

Товор товор алхлах морьдын ган туурай замын хуурай шороог эргүүлэн урвуулан шид лэх тоолонгоор олон мянган жил хүн малын хөлд ханатлаа тээрэмдүүлсэн өлөн тоос агаарт пур хийтэл ялгаран хоцроод аажмаар дээ шээ дэгдэхийг хараад байвал дөрөөн дор урагшаа мөлхөх илбэт дамраас хөврөн үлдэх цав цагаан утсаар тэн гэрийн хаяатай холбогдсон мэт ээ. Морьдын алхах хэмээр эмээлийн бүү рэг цохих туламтай зэнгүүнээс үүсэх бүгт дуу улам улмаар чихэнд шингэх нь их талын зүрхний лугшилт мөн шиг санагдана. Нар өгсөх тусам үүлэн бөмбөлөг тэлэн томорч, дотогшоогоо зузааран бүүдийвч, нар хараахандаа ил, мөчөөс мөчид улам ч галзуу шарж байв. Өвсний толгой үл хөдөлнө, тарган голио замаас зайлмагц хайрган завсар балхайн хэвтэж морьдын хөл рүү тэнэг нүдээр бүлгийтэл гөлөрнө. Аадар орох нь илт боллоо.

Их талыг туулах морьтны заншлаар бид нэг нэгнийхээ бодолд саад бололгүй дуугүй явцгаана. Жанибекийн эмээл дээрээ нугдайн суусныг бодоход ун таж яваа юм шиг, үрчлээсээр дүүр сэн нүүр нь аль дивангалавт орой дээрээс харван буусан хад чулуунд хүй яз татуулаад түүнээс нааш нар, салхи, усанд идэгдсээр байгаа уулын атираат хормойг санагдуулна. Уруулаа тас жимийсэн нь нууц алдахаас сэрэм жилсэн мэт, магнай дээр нь хоёр гүнз гий, гялгар сорви дамналдан тогтжээ. Урт чихэвтэй хурган мал гай нь хуу чирч, хөвөнтэй хүрэм дороос цу хуйх дээлийнх нь хормой дороосоо сэмэрчээ. Харин урт түрийтэй савхин гутал нь шинээрээ байв. Эртний хийцтэй карабин бууных нь замгийг даавуугаар сүрхий зузаан ороож боос ныг харахад тэрхүү галт зэвсгийг тас гинжлээ юу дээ гэмээр.

Хөхрөн униартах алсад Таван Богд сүндэрлээд хурц наранд гялалзах цаст оргил өөд нь харахын төдийд нүд чил нэ.

Хайрхан уулаа хартал холын Ис лан д бодогд лоо. Зүс үзээгүй атал, зүр хэнд орших тэр орон, бэрх түүхийг тэсвэрлэн үлдсэн хүн ард нь сэт гэлийг минь эзэмдэнэ.

Ертөнцийн нөгөө хэсэгт төрсөн малчны хүү миний зүрхэнд эх орноо шингээж чадсан суут зохиолч төрсөн ах минь шиг дотно санагдаад нүдий минь нулимс бүрхэх янзтай. Энэхэн үед аян замынхаа нөхрийг харлаа. Үрчлээт царай, нууц хадгалан жимийсэн амтай энэ тува өвгөн цагийн нэгэн ну га чаа, ертөнцийн нэгэн хязгаарт төр сөн морьтой хөшөө чухамдаа мөн байлаа. Түүнийг харах тутам цагийн аяар цээжинд минь хуралдсан нулимс ундрэн ундрэн гарав. Энэ бол сархдын шилнээс дэгдэх нялуун гут ралтай төсөөгүй, өнгөрсөн ба ирэх эриний зааг дээр болж байгаа хүнд хүчир гайхамшигт өөрч лөлтийн агуу ихэд бишрэн донсолсон сэтгэлийн минь хүлээс тайларч байгаа хэрэг байлаа. Энэхүү морьт хөшөө, түүний урьд болон хойно эзгүй зай эс үлдээн өвөрмөц түүхээ сийлэн яваа миний ард түмний хувь заяаг алсын ах дүү нарын зүрх сэтгэлд хүргэх билэгтэй хүү төрөх өдөр бий гэж бодтол цээж уужран, сэтгэл тэнийгээд явчихав.

Тэнгэр нүргэлэх шиг болов. Морьд чихээ сортосхийлгэн, толгойгоо өр гө нө. Жанибекийн аниастай нүд тат вас хийснээ зовхин завсар нь бяцхан ба раан зураас гараад ирэх нь тэнгэрт юу нүргэлснийг бодож, эрж байх бо лол той.

Би нүдээ гараараа арчаад удтал эрс ний эцэст асар өндөрт бяцхан гя лаан цэг зүүнчээ явж байхыг олж харлаа. Агаар гэдэг тэр аяараа шувуу, элээ, хэрээ, болжор, тагтаа... зүсэн зүйлийн жигүүртний дунд мөнгөн цагаан цах лай бүхнээс содон харагдахад өрөвдөх сэтгэл өөрийн эрхгүй төрөн ийнхүү бодогдоно.

“Хөх далайд амьдрагч чи өвөг дээд сийнхээ гаргасан замаар бас л наашаа ниссээр үү? Сая жилийн өмнө тэднийг чинь умбуулан, тэжээж байсан их далай цагийн эрхээр ширгэн арилаад, оронд нь гагцхүү өнгөрсний ул мөр элс, чулууных нь ширхэг бүрт нь шингэж хоцорсон цэнхэр тал л үлджээ. Аяа, угаас заяасан нутаг гэдэг юутай гайхал тай хүч вэ?”

Шуурганд хийссэн өөдөс мэт, тэнгэрт бужиг нах шувуудыг хараад байтал толгой эргэх бөгөөд тэдний гуаглаж, исгэрч, дуу хадах нь орчлон гийн энэхэн хэсэгт багтах оронгүй болсон амьтдын дуу шуу шиг гутранги түгшүүртэй дуулдана. Жигүүрээрээ агаарыг нэн хүчтэй алгадах тул тэр нь нүргээн жиргээн дотроос ялгаран сонсдохоор барахгүй салхи нь хацар нүүрэн дээгүүр сэвэлзэх нь мяралзах давалгаа сөрөн явахыг санагдуулна.

Онгоц удам тал дээгүүр нисэн ниссээр, энэ завсар бөмбөлөг байхаа нэгэнт болин оволзох далай болон хувираад нарыг нөмрөн залгисан хар үүлний цаагуур орлоо.

Бид хоорондоо үг сольсонгүй бо ловч, эмээл дээрээ нэгэн зэрэг ухас хийн өндийж, жолоогоо угзар магц морьд нижигнэтэл цогиж гарлаа. Сал хи сэвсхийн босч, ирсэн зүгийг маань биднээс таслах гэсэн мэт агшны дотор тоос хөөрөгдөн, цээж давчдуулав. Тэг тэл өмнөх, тэнгэр өрлөсөн цаст уулс, оройноос нь бэл рүү харван буусан нэлгэр цагаан мөсөн гол нүдэнд тустал ирэх алжаалын аймшиг хийсэн арилах шиг болон үүл задарч, цас орвол ч орог, гагцхүү зорьсон хэрэг минь л бүтээсэй гэж бодогдов.

Үдийн алдад тэнгэр харанхуйлаад явчихсанаа баруун хойноос гэнэт бөөн элс, хайрга хийсгэсэн нүүр нүдгүй шуурга овсхийн босч ирээд арай л эмээлээс ховх шидчихсэнгүй.

Урьдаас далбилзан ойртох того руу нуудыг харвал шуурга сөрөн ни сэх тэнхэл нь нэгэнт

барагдаад өөрийн мэдэлгүй явж байгаа нь илт. Жанибек нэг юм хашгирсан боловч би ойлгосонгүй, гайхахдаа зогсё гэж дохилоо. Өвгөн надруу бөхийж, чихэнд минь “Хажуугийн салаа хүрч аадар өнгөрөхийг хүлээ” гэлээ. Хаа шаа ч харсан тэр гэж таних юм алга тул гагцхүү салхиар чиг барьж баруун урд зүгийг тэмүүлэн давхилаа. Шуурга намжихын завдалгүй бороо хүрч ирэв. Салхины исгэрээн, туурайны тачиг нааны цаанаас эхлээд шивнээн шиг, дараа нь улам улам ойртох нүр гээн шиг дуулдсан аадар бидний дээ рээс угсраа тэсрэлтээр амилах ной тон түймэр мэт тасхийн буулаа. Бид мориныхоо амыг татав. Хайрган хөрсөн дээр ташуу тусаад үсрэн ойх том цагаан дуслууд дөрвөн зүг найман зовхисоос зэрэг цахилах аянгын гал, түүнээс үүсч хоорондоо хэдэнтээ мөр гөлдөн хэдэнтээ нааш цааш ойх аянгын нүргээн доор их талыг бүрхэн цовхрох буман цэгээн хорхой шиг язганан, гялтганан харагдана. Унасан морины дэлнээс хөх дөл сүүмэлзэн, хярвас ханхлах шиг болоход адгуус шилгээн, толгойгоо урд хоёр хөлийнхөө завсар хийн авч давхих гэнэ. Зогсоох гэж жолоог угзартал бүр янцгааж ирээд цамнасан тул зөнд нь тавьж орхихоос өөр арга байсангүй. Гэтэл морьд ухас хийн давхимагц дэлэн дээгүүр нь түрүүн сүүмэлзэж байсан дөл одоо бүр дүрэлзэж орхидог байна.

Элгэн хадны өвөрт өвөлжөөний чулуун хо роо харагдлаа. Би эцгийнхээ гэрийг үзсэн юм шиг баярлан энд өөрийгөө үхэлд гүйцэгдэшгүй мэт саналаа. Дав хисан чигээрээ хашаан дотор орж, ураг шаа бөхийсөн хадны ёроолд хү рээд очвол бороо, салхинаас нөмөр, дулаахан байв. Мориноос буув, гэтэл бүр голдоо ортол норж, бээрчихсэнээ эмээлээс салсан хойно сая л мэдрэн, хөдөлж ч чадахгүй, сууж ч болохгүй дагжин зогсч байв. Өвгөн ажиггүй яв саар агуйн мухарт очиж суух гэснээ намайг хараад болив бололтой, тон гойж газраар нэг хөглөрөн хэвтээ хар хөх аргалаас нэгийг авч хэмхэлж үзэв. Тэгснээ сөхрөн сууж аргалыг зэрэглээд алган завсраа хомоол үрж голд нь овоолоод, өврөөсөө шүдэнз гаргаж алгаараа салхи хаан зураад нун таг хомоолд дөхүүлэн барив. Тэ гээд нарийхан цэнхэр утаа дээш дэгдэхэд өвгөн сая л гараа татаж босоод уугьж эхэлсэн галыг хормойгоороо хэд сэвтэл дөл цайлалзан, удалгүй гал дүрэлзэн аслаа.

Би ч санд мэнд хүрч галд ээв, гэтэл бүүр ч айхавтар дагждаг юм байна. Жанибек на майг хараад урам нь хугарсан, өрөвдсөний али ныг бүү мэд инээмсэглэх аядав. Би түүний инээм сэглэхийг анх удаа үзэх минь энэ. Гэтэл тэр нь эртний уулархаг нут гийг санагдуулам нүүрий нь харамс маар эвгүй харагдуулах аж. Магнай дээр нь дамналдан тогтсон өнөөх хоёр сорви мөнхийн шийтгэл болж дээ гэж бодлоо. Гэхдээ зовлонт инээмсэглэл төдхөн унтарч, аяны нөх рий минь царай хуучин янзандаа эргэн орсонд миний сэтгэл амрах шиг болов.

Жанибек дотроос нь нэгнийг эрэх мэт дөл рүү ширтэн сууснаа надаас “Хэдтэй вэ?” гэж асуулаа. Би “Хорин тавтай” гэлээ. Зовхио өргөн над руу нэг том харснаа аман дотроо нэг юм бувтнаснаас нь би ганцхан “...томоогүй золиг...” гэсэн үг ойлгож хоцорлоо.

Бороо орсоор л боловч аянга хоорондоо арай ч зайтай цахилна. Гагцхүү хадан доор болоод дуу нь улам ч сүртэй нүргэлнэ. Тасхийх тоо лонгоор нь морьд маань давхийн цо чиж байв.

Өвдөг дээрээ сөхрөөд, байдгаараа урагшаа бөхийчихсөн аварга биетнийг санагдуулам, өвөрт нь бүхэл хот хонь уужуухан багтах зайтай энэ хадны нөмөрт айл өвөлжилгүй олон жил бол сон бололтой, чулуун хороо нь энд тэндээс сэтрэн нурж, өтөг нь үйрч салхи шуурганаар хийсэн ирсэн элстэй холилдон шороожоод гэ рийн буурь дээрээс нурсан хайрганд булагджээ.

Хаврын шуурга, намрын борооноор туугдан ирээд нөмөрт нь хоргодон хоноглодог алдуул, завхуул адуу, тэ мээг эс оролцуулбал ийшээ чиглэх амьд амьтан үгүй бололтой.

Ажигласаар байтал, анхандаа эцгий минь гэр шиг дотно санагдсан эзгүй хээрийн энэ өвөлжөөнөөс нэг л сүрдэх шиг болов. “Энд айл өвөлжихөө бо лиод удаж байгаа юм байх даа” гэтэл Жанибек агзасхийн цочих шиг болж намайг ширтсэнээ: “Хорин таван жил болж байна” гэх нь тэр! Би балмагдаж хоцорлоо. “Хорь гаруй” юм уу “Хорин хэд” гэсэн бол өөр хэрэгсэн, бүр яг “Хорин тав” гэж мэдэж байдгийн учир юуных билээ?!

“Яасан юм?” гэж би тэсэлгүй асууж орхив. Жанибек дуугарсангүй.

Аянга цахилж, хөхөлбөр гэрэлд нь магнай дахь сорви нь гялсхийв. Да раа нь хад дотроосоо хагарах мэт тасхийсэнд мэдсээр, тэр ч байтугай энэ дууг тэсч ядан хүлээж байсан мөрт лөө, би сүрхий цочив. Жанибек санаа алдав. Зүрх минь түгшүүр зөгнөн лүг лүг лугшиж байлаа.

Гал асч дуусав. Би баахан хуурай аргалын хог хамж цог руу хаяснаа, ахин явж бүтэн хормой аргал авчирч нэмлээ. Дүрэлзсэн гал асаасай гэж бодсон минь, дүрэлзсэн гал аслаа. Жанибек дөл рүү ширтсээр “Өвөлжөөний эз ний хээс хүн үлдээгүй юм” гэлээ. Аян га цахилаасай! гэж бодогдов. Гэтэл аадрын хөг нэгэнт өнгөрч оронд нь шив рээ бороо нэг хэмээр шивнэн орж, дэлхий зүүрмэглэж эхэлжээ.

Дараа нь Жанибек ингэж ярилаа: “Баянакийн тухай дуулалгүй л яав гэж, тэр чинь энд дууссан юм даа. Гэхдээ чиний дуулсан тэрний чинь нэг хагас нь худлаа, нөгөө хагас нь дутуу дулим юм байж таарна. Тэр бүхнийг яг үнэн болсноор нь мэдэх хүмүүсээс одоо орчлон дээр би л ганцаараа үлджээ. Магадгүй, миний үхэл маргааш ч юм билүү, ер нь тэгээд заавал маргааш биш ч гэлээ, нэг л өдөр унаад өгөх нь хууль шүү дээ. Тэгээд ч энэ түүхийг би чамд ярьж үлдээе. Бодвол чи Баянакийг Доёбуу гэдэг хүний хүү гэж дуулаа биз ээ. Худлаа, миний, миний ганц хүү байсан юм. Доёбуугийнх гэ дэг болсны учир нь тэр этгээд хүүгий минь эхийн хэвлийд байхад нь булааж авснаас гарсан хэрэг. Цаадах нь сайхан ч амьтан байсан юм. Үс гэзэг, нүд шүд гээд л хүнд байдаг бүхэн нь сайхан гээч. Өөрийнхөө тухайд гэхэд эх эцэг, орон гэр гэж мэдэх юм алга, тэглээ гээд түүндээ гутрах ч тэнхэлгүй, ёстой намайг хэн хэлэхэв, нохойг хэн саахав гээд бодчихсон улаан галзуу амьтан явжээ. Өнөө сайхан амьтан чинь тэ гээд тийм хүний юунд нь болсон юм, надад хичнээн сайн байсан гэж бодно. Өнөө хүртэл би гайхдаг юм шүү. Баячууд надад дургүй байсан нь илэрхий, гэхдээ ядуусыг надад талтай байсан гэж бодно уу, үгүй! За ер нь тийм амьтанд өнөө ч гэсэн хэн л дуртай байхав. Бүр улаан галзуу явжээ гэж чамд хэлээ биз дээ.

Доёбуу, гар хоосон, гуя шалдан яваад гэнэт хөрөнгөжихийн ухааныг ойлгосон хүмүүс ямар байдгийг чи мэдэх үү? Тэдний л нэг дээ. Оросын худалдаачидтай сүлбэлдэж, хэдэн са раар алга болчихсоноо нарийн ширийн бараатай ирж түүнийгээ гүйлгэнэ, заль гэж үнэг шиг, бас түүн дээрээ бүр шийдчихсэн амьтан л даа. Хөөрхийг минь надаас булааж авахдаа жирэмсэн байсны нь мэдээгүй гэж санана уу? Ер нь сайхан царайд нь ч биш, эхийнх нь хэдэн малд нь л болсон байх гэж боддог юм шүү би. Цаадах нь өөр хүүхэд шуухадгүй, хоногоо хүлээсэн, айхавтар бие муутай хүн байсан юм чинь. Тэгээд ч охин нь гэрлэсний тун дараахан л яваад өгсөн дөө, хөөрхий. Энэ бүхэн 1920 онд болсон хэрэг.

1921 он манай бөглүү хязгаарт их шуурга шиг сүртэй бус, үүрийн гэгээ шиг зугуухан ир жээ. Буудалцах нь ч буудалцсан, гэхдээ маний бууны ам гагцхүү орос, хасагийн эх оронгүй дээ рэмчдийн өөдөөс чиглэсэн юм. Шинэ өдрийн гэрэл гэгээнд баян, хоосон хоёр нэг нэгнийгээ дайснаа гэж таньж авсан боловч хоорондоо нүдэлцээгүй нь бидний дайсан зэвсэг далайгаад далайгаад сачий нь хүрэхээ нэгэнт өн гөрснийг ойлгосноос болоо биз.

Гэхдээ тэд зэвсгээр дийлэхгүй зүй лээ ухаа наар алдахгүй байхаар шийдсэн нь баяд ноёд, хамба зайран сүргээрээ ардын засгийн анхны төлөөлөгчийг хадаг самбайтай угтсанаас илэрхий. Тэдний араас бас Доёбуу болон түүний өрөөсөн панзчид, луйварчид, ашиг хон жоо эрэгсэд дагалдав.

Ядуучууд бид ч бас хоцорсонгүй. Шинэ засгийн төлөөлөгчдийг томилоход хүмүүсээ ч орууллаа. Ялгаагүй дээ, нэг л хэсэг эд хөрөнгө ч үгүй, эрдэм сургууль ч үгүй, миний л ижил амьтад. Бас нөгөөдүүл ч өөрсдийн хүмүүсээ шургуулж чадсанаар барахгүй тэдгээр нь биднийг бодвол бичиг үсэг, монгол хэлийг гадарладгаараа яггүй эрдэмтэйд тооцогдох улс юм гээч.

Төдөлгүй анхны ардын багш ирж, хэсэг хүнд бүлгэмээр бичиг үсэг заасны дотор нь би орж, унших, бичихийг сурахын хажуугаар Ленин, Сүхбаатар, дэлхийн улаан пролетари, Октябрийн хувьсгал болон бас бусад зүйлийн нэр усыг дуулж авлаа. Бас хөрөнгөтэй хөрөнгөгүй хоёр анги байдаг, хөрөнөггүй нь хөрөнгөтэйгөө устгах ёстой гэж мэдэж авлаа.

Бүлгэмээ дуусгатал надаар ардын багш тавьчихдаг юм байна. Яахав, дуулсан, сурснаа бусдад дамжуулсан болж, өөртөө ахадсан ажлаас сүрдсэнгүй, хүчин зүтгэж гарлаа. Цагаан гэртэй, бас гэр нь цагаан биш боловч зуугаас илүү толгой малтай болгоныг би хувьдаа нударган, дайсанд тооцно. Миний дайсан олон байлаа. Эхийнх нь хэвлийд алдсан хүү минь төрөөд, бүр хөлд орчихсон цаг л даа. Өнөө чинь, Баянак. Эх нь Суяш. Доёбууд ахиад хүүхэд төрүүлж өгсөнгүй, үүнд сэтгэл минь бяцхан өег явдаг байлаа. Доёбууг эзгүй хойгуур гэрээр нь бууж Баянакаа цээжиндээ тэврэхдээ хүүхдийн зөөлөн хонгор үнэрт мансуурах шиг болно. Суяш минь мэл тэлзсэн нулимсаа барьж ядан дуугүй сууна. Нэг удаа бүр мэлмэртэл уйлж орхиод сүүлд нь мэгшүүлэхийн хажуугаар инээмсэглэн “Чамтай улам л адилхан болсоор байгааг харж байгаа биз дээ?” гэж билээ. Харвал нээрээн л адил ч юм шиг, харин нүдий нь үзвэл эхийгээ хуулжээ гэмээр. Яваандаа хүү минь намайг угтан гүйж ирдэг болов, харин “ахаа” гэнэ. Тэгэхэд нь би өргөж, эмээл дээрээ суулгаад өөрөө морио хөтлөн явахад баярласандаа инээж, хашгирч алдана гээч. Доёбуутай бол ингэнэ гэж үгүй, өвөр дээр нь ч суудаггүйг Суяшаас дуулсан юм. Гэхдээ цаадах нь зодож зандраад байдаг юм уу гэвэл бас ч үгүй гэнэ. Доёбуугийн гэр хэзээ л хүн амьтнаас зайдуу уулын нэгэн мухарт явна. Тэр үед би үүнд нь баярладаг байж, одоо бодоход энэ л миний хүүд хожим гай болжээ. Учир нь Баянак шилийн ан шиг зэрлэг, зоргоороо өсчээ. Шилийн анг барьж ирээд саравчинд хашихад яадаг билээ? Тэр хоёрыгоо өөр дээр авчихгүй яасан юм бэ? гэж чи надаас асуух биз. Үүнийг би өөрөөсөө гучин жил асуугаад хариу олохгүй яваа юм. Тэр үед гэр бүлийн хууль гэж ямар байсан биш, яваад өгсөн эмэгтэй хүний чинь хойноос хөөцөлдөх юм гэж хаягдсан авааль эрээс нь өөр байсангүй шүү дээ. Авааль эр яахав дээ, сайндаа л нэг нүдэх гэх биз. Доёбуугийн хувьд бол нүдэлцээд ч гавихгүй байсан л даа. Дуу шуу нь хүртэл эм хүнийх шиг жингэнээд, хорчийж тагжийсан амьтан байв. Тэгэхэд намайг хорин таван насан дээрээ ямаршуу эр явсныг

баргийн хүн төсөөлөөд мэдчихнээ.

Одоо бодоход, нэр алдраа хиртээ хээс айсан хэрэг юм уу даа. Битгий гайхаарай. Тэр цагт ардын багш болноо гэгчийг юу гэж санана чи? Ихээ том тушаал гэсэн үг. Тэгээд ч тэгсэн юм байлгүй, би гэдэг хүн өөрийгөө хүн хүнээс онцгойд тооцчихоод, нэгэнт тийм болохоор бас өчүүхэн ч өө сэв гүй, алдар нэр ариун явах юм шүү гэж бодоод орхиж л дээ. Биеэ тоох гэгч чинь л энэ дээ. Нэргүй том өвчин. Гэхдээ энэ бол зөвхөн эхэлж байсан үе нь байж. Хожим түүнээс өндөр албан тушаалд дэвшсэний дараа ёстой л гаарч билээ.

Долоон үеийн гуйранчин! Урьд бол хүмүүс намайг гоочилж ингэж нэрлэдэг байж, хожим болохлоор би өөрийгөө дөвийлгөж ингэж нэр лэлээ гээч. Долоон үеийн гуйранчин, эрдэмтэй, чадалтай, сайхан - Тийм ээ сайхан! Үүнд итгэхэд чамд ч хэцүү байж магадгүй, гэхдээ тэр үед нүүр минь сорвигүй явсан гэдгийг санаарай. Уг нь хожим бодоход би гэдэг чинь аль эрт шийтгэл хүлээх, өрөөсөн нүд нь сохрох ч юм уу, өрөөсөн хөл нь хазгар болбол зохих амьтан байсан байдаг шүү.

Миний бие Баянак, Суяш хоёртоо заримдаа бүр аюулхай цээж хөндүүрлэм хайр хүрдэг байсан боловч биеэ тоох гэгч минь хэтэрснээс хүний эхнэртэй нэр холбогдохоос айсан минь түүнээс хүчтэй, ингэхлээр үнэндээ сүрхий хулчгар гайхал байжээ. Ижил ханьгүй, амьдрал минь ядуу, өлсөх, даарах өдөр олон, товчхондоо өнөөх л алдартай гуйранчин хэвээрээ үлдсэн ч гэсэн өөрийгөө Лениний шавьд өргөмжлөн, дэлхийн улаан пролетарийн яс махны тасархай, ган бат зоригтой, цэвэр ариун ёс суртахуунтай хувьсгалчийн хувьд хуучин амьдралын балгасан дээр хувьсгалт амьдралыг цэцэглүүлэх хүсэлдээ хөтлөгдөн толгой гэдгэр яв лаа гэсэн үг.

Гучин онд миний бие сумын дарга боллоо. Нам, байлдагчийнхаа ясыг танилаа даа гэж боддог юм байна. Сэтгэл минь ариун байсан нь худлаа ч биш, ардын засгаас амь насаа хайрлалгүй явсан минь үнэн. Гагцхүү дээрх бөндгөр минь хоосон байсан нь харамсалтай. Хэрэв миний эрх хүрдэг байсан бол хамаг сүм хийдийг ламтай нь, номтой нь галдан, хамаг нударганчуудын нармайг цааш нь чихчихээд үлдсэн бүгдийг нүд ирмэхийн зуур хамтралд тас зангидаж орхих байсан юм. Даанч олонхи нөхөд намайг тэвчээргүй байна гэж буруушаах аястай. Тэд бол миний хувьд эвлэрэгчид байлаа.

Гучин хоёр онд ч гэсэн манай энд буудалцахад хүрсэнгүй. Гэхдээ энэ бол тайван өнгөрлөө гэсэн үг биш, худал цуурхал, хорт ухуулганаас, галдах бусниулах, хил давах хүртэл юм юм л болж байв. Ардын намд шургалсан чинээлэг зарим этгээдийн тар нь танигдаж, тэдний амнаас Алтай давж, ардын засгаас буруулах тухай үг яриа дуулдах болов. Ядуу биднүүс дотроо нууц хурал хийж, яахаа зөвлөлдлөө. “Та нар миний тэвчээргүйг шүүмжлээд байсан. Тэвчсээр суутал юунд хүргэх гээд байгааг харцгаав уу, одоо?” гэж би нөхдийнхөө амыг асуухдаа бах минь ханасангүй, харин өөрийгөө олон нөхөд дотроо орь ганцаархнаа алсын хараатай байсан юм гэж үү? гэж үнэнээсээ сэтгэл донслон бодож байлаа. Бид ардын засгаас санаа буруул сан этгээдийг өрсч дайрахаар тогтов. Тэгээд дайрсан ч, ялсан ч юм”.

Жанибекийн хацраа гал дээр тогт жээ. Тэрхүү байдал нь хоёр эриний бос гон дээр ертөнцийн энэхэн алс бөглүү хязгаарыг донсолгосон шуур ган жилүү дийн дүр зураг дөлөн дотроос түүний нүднээ амилан харагдаж байна уу даа гэсэн бодол төрүүлнэ.

Бороо тал, бэлээр шиврэн орсоор боловч уулсуулын оройд манан тогтсон нь удалгүй үүл сарнин, ахин нар шарж, дэлхий униартан, цар цаа жиргэхийн зайлшгүйг илчилнэм.

“Нударган, буг лүд, бөө ламтайгаа тонилж, харин Доёбуу мэтийн этгээд үлдэв. Тэдний амин гол өнөө хүртэл бүрэн тасраагүй, араас чаргуулдсаар л байна. Доёбуу хоршооны дар га болж, төрийг ч хохироохгүй, түмнийг ч гомдоохгүй сайн хүний царай гарган, дундыг барьсхийн гэлдрэхдээ хувийн мэр сэр ашгийг мартсангүй. Түүнийг харахаас дургүй минь хүрэвч түүнд хонзон өвөрлөсөнгүй, ингэсэндээ ч өөрөө урам шиж явдаг байв. Бодоод байхад өөрөөс минь улам улам л сайхан чанар олдоод байх шиг. Би гэдэг чинь хүнд зөвхөн хонзон эс санахаар барахгүй, бүр даанч уужим сэтгэлтэй хүн шиг өөрт санагдахын учир гэвэл мөнөөх Доёбуутай далим л гарвал ярьж хөөрч, тэр ч байтугай, хэдий заримдаа ой гутагч, түүнтэй найзар хахаас ч буцахгүй байлаа. Энэ бүхнийг нийгмийн эрх ашгийн үүднээс хийж байна гэж бодож явжээ.

Цалин минь одоо чамлахааргүй өссөн бо ловч амьдрал минь нэг л хэвэндээ, тарчиг дар жин, гэхдээ би үүндээ гонсойх нь бүү хэл, бүр додигор явдаг байв. Учир нь чинээлэг амьдрал гэгч нь миний хувьд феодал хийгээд жижиг хөрөнгөтний хэрэг байв. Сонин дээрээс олж харсан жижиг хөрөнгөтөн гэдэг энэ үг бол мэдээж миний дуртай хэлдэг үгийн нэг, урьд нударганд тооцож явсан бүхэн минь одоо нэгэнт нударгангүй болсон цагт миний хувьд жижиг хөрөнгөтөн болж л дээ. Би гоонь ганцаараа, урьд хамба ламын залбирал үйлддэг байсан бяцхан дүнзэн байшинд суудаг байв. Жил өнгөрөх тутам Суяштайгаа уулздаг минь улам цөөрсөөр. Хааяа очиход минь өөдөөс айсан байдалтай дүрлийтэл ширтэнэ. Урьд яриа хөөрөө нь дуусах гэдгийг мэддэггүй байсан бол одоо асууж шалгаахгүй л бол эс дуугарна. Харин очих болгонд нэг хоёрын зэрэг дотуур өмд, цамц заавал оёод тавьчихсан байна. Өнөөхийгөө дэрэн дороос гаргаж ирэх дээ “Хичнээн ч олон сар нуув даа. Заримдаа өнөөхийг чинь ор дэр уудлаад харчих болов уу гэж айгаад. Бас заримдаа чамайг хиртэж, бөөстөж орхих бий дээ гэж сэтгэл зовоод. Наашаа хүрээд ирэх зай зав гарахгүй бол Хенже эгч дээр очиж бай л даа” гэнэ. Тэрхүү Хенже эгч гэдэг нь ядар сан амьтдыг тэтгэдэг сайхан сэтгэлтэй ав гай байсан юм. Өөрийн гэх ах дүүгүй юм уу тэдгээр нь хэрэгсэхээ больсон хэл амгүй, дүлий, сохор, ухаан мэдрэл сул, өнчин өрөөсөн амьтад бултаараа л тэр муу ядуу бүсгүйг тойрон амь зуудаг байв. Хөөрхий минь насан элэн элтлээ бас миний төлөө санаа тавьсаар байсан юмсан.

Гэрлэх барих тухай бодож явсан минь ховор билээ. Бүсгүй хүнд сэтгэл татагдах явдал бас чиг байлгүй л яахав, харин яг үүнтэй чинь нэг насны амьдралаа холбочих юмсан гэж бодсон минь үгүй. Яагаадав гэхэд ингээд гээд хэлчих тоймтой юм алга. Хожим бодоод байхад, өөрийгөө нэгэнт бүхнээс дээрд бодчихсон надад бүсгүйчүүлийг өөлөх шалтаг мундахгүй олддог байж л дээ. Ухаандаа царай зүсний сайхантай хөөцөлдөөгүй юмаа гэхэд намтай нэг нь номгүй, номтой нь намгүй байх жишээтэй. Арван хуруу тэгш хүн олдоогүй, олдох ч үгүй байсан. Суяшийн тухайд гэвэл, урьдын дүрэлзсэн хайр сэтгэлээс минь хааяа хааяа улсхийхээс хэтрэхгүй цогийн төдий юм үлдсэн байлаа. Гайхалтай нь энэ галыг унтраасан эзэн нь би өөрөө гэдгийг мэ дэж түүгээрээ дотроо бахархаж явдаг байжээ, чааваас.

Баянак минь шөнийн хоногоор суга өсөн сай хан ч, галтай ч эр болов. Арван гуравтайдаа чоно намнаж, хаана л хүчрэгдээгүй эмнэг хангал бай на, түүнийг бүр сураглаж очоод унадаг байсныг нь бод л доо. Тэгэхдээ залхуу алдартай, яагаад гэхлээр жилийн дөрвөн улирлыг морин дэл дээгүүр өнгөрүүлэхээс Доёбуугийн өнчин иш гийг ч өдрийн хугас хариулсан нь

үгүй юм чинь. Сүүлд сумын төвд сургуульд орох юм боллоо. Арав ч хоноогүй юм байх, оргоод харьчихжээ. Нэгэнтээ би Доёбуутай ийм яриа үүсгэлээ. “Нөхөр Доёбуу та хүүгээ сургуульд өгөх нь яасан юм бэ? Ингэснээр бүдүүлэг хоцрох нь байна шүү! (Тэр үед бичиг үсэггүй хүнийг би бүдүүлэгт тооцдог байлаа л даа) Бидэнд эрдэм боловсролтой залуу үе хэрэгтэй!”

Гэтэл Доёбуу санаа алдан ингэж хэллээ. “Та ных зөв өө. Харин цаад хар маанаг чинь даанч юм сурахгүй л дээ. Ямар юмаа дуурайчихсан юм бүү мэд. Намайг л биш дэг!”. Ийм үг дуулсандаа нүүр минь халуу шатаж, хариу үг хэлэх байтугай, хааг гэж дуугарах тэнхэлгүй болж хоцорлоо.

Ганц хүүгээ өсөхийн хэрээр зэрлэгшихийг алсаас ажиж явахдаа нэгд бахархан, хоёрт гашуудавч, түү ний гээ өөр дээрээ авчих зориг надад байсангүй, харин ч паянгий минь амьтан мэдчихвий дээ гэж хул чигнадаг байлаа шүү. Тэгэх юм бол ёс суртахууны хувьд цэвэр ариун байх учиртай удирдагч биеэр ойрын нэгэн ажилтныхаа гэр бүлийг үймүүлжээ гэсэн шуугиан гарна даа гэж бодохоос яс хавталзана. Ингэхдээ бүр гэр бүл үймүүлсэн, хулгайлсан этгээд би биш, Доёбуу гэдгийг бүрмөсөн мартаж орхисон хэрэг болж байна даа, түй үхээр!

Тийм дээ, хүү минь, албан тушаал, нэр алдрын донд нэг л автах юм бол хараастай сохор, мэдээстэй маанаг болж хувирах нь амархаан байдаг. Ийм хүн нэг ёсны эрхтэн дутуу, мэдрэл гажуу явсаар нэг л өдөр амьдралын хатуу торгуулийг голдоо ортол мэдрэх дээ сая л сэхээ ордог. Сэхсэний дараа ч бол юутай гайхалтай, юутай харамсам амьтан болчихоод явснаа харин нэг ойлгож авдаг юм билээ.

Гээд хувьсгал энэ нутгийн хөрсөнд нэгэнт үндэслэсэн байлаа. Учир нь тэрээр харанхуйн дараа гэгээ орох, хүйтний дараа дулаан болох шиг жам тай, нэг юм уу нэг хэдэн тэнэг толгойн баруун юм уу зүүн тийш хадууран давхиснаас болоод алдуурччихааргүй, агуу их зүйл юм даа.

Гучин есөн онд Суяш минь нас бар лаа. Нам рын нэгэн дүнсгэр өдөр хяруу татсан булшны овгор шорооны өмнө зогсч байхдаа бараг хоёр жил уулзаагүйгээ саналаа. Тэгтэл нүднээс минь доголон нулимс бөмбөрөн уна санд би ичихээсээ илүү цочив. Миний нүднээс нулимс гарах юм гэж би мэдээгүй явжээ. Суяш минь гучин долоотой байлаа. Доёбуу тэр өвөл нь л нэгэн нударганы бэлбэсэн авгайтай гэрлэлээ. Урьдын бүдүүлэг цагт хань нөхрөө чөлөөтэй сонгож авах эрх мэдэлгүй байсан бүсгүй хүн шинэ, боловсон цагийн буянгаар тэр эрхээ ашиглаж байгаа юм гэнэ.

Баянак Доёбуугийн, Доёбуугийн ч гэж дээ, түүний нударган авгайн гэ рийг орхин одсон байв. Нэг шөнө сүр хий унжирсан хурлаас тараад харьж ирвэл муу байшингийн минь үүдэнд нэгэн өдөр залуу зогсч байснаа намайг таньж амжаагүй явтал өөдөөс минь хүрч ирээд: “Аав аа” гэж сулхан дуугардаг байна. Баянак гээч! Суяш минь хүүдээ үнэнийг хэлж амжсан байж!”

Жанибекийн хоолой нь зангирс хийгээд дуу гүй болчихлоо. Эргэн той рон нам гүм. Бороо зогсчээ. Гал асч дуусаад улайхын төдий цог л үлдсэн байв. Цогийг хөндөж, тойруулан аргал зэргэлж, тархиа дүйртэл үлээлээ. Гал ахин дүрэлзэн асаасай гэж бодсон минь, гал ахин дүрэлзэн аслаа. Бороо өнгөрч, арсгар цагаан үүл шил даван нүүнэ, арсгар цагаан үүл тал гатлан нүү нэ. Цас, цас орох нь байна.

“Би гэдэг хүн баярлах мөртлөө айж хоцров. Харанхуй дундаас гэрэлтэх тун галаг царайтай, өндөр сайхан за лууг цээжиндээ тэврэн, “би чинь ийм хүүтэй хүн юм байна шүү дээ! гэж бахархан бодовч, сумын дарга, хоршооны дарга хоёр хоорондоо нэг хүүгийн будлиантай юм байх аа гэсэн яриа орон гүрнээр л нэг дэгдэх биз гэж бодохоос айдас хүрнэ. Эцэст нь айдас дийлж: “Орон гэр, эцэг, эхтэй хүн чи буц даа” гэж тэмүүлэн ирсэн хүүдээ хэлж орхилоо шүү, мангуу үхээр чинь! Баянак агзасхийн, надаас зайлж, харанхуйд дорхиноо бараа тасран одоход яс, мах минь янгинах шиг болж хүйтэн цоожинд духаа наан хоцров оо би. Харин буцаан дуудах, араас нь гүйх ухаан даанч төрсөнгүй.

Тэр намар Баянак цэрэгт мордлоо. Байдал түгшүүртэй байсан цаг. Сумын урьдах хөтөл дээр арван хоёр залуу эр алсын моринд дөрөөлөн жагсчихсан, жагсаалын эхэнд улаан туг намирч байв. Шилийн сэрүүн гол руу сэв сэв нэвтэрч эхэлсэн намрын өдөрсөн. Жагсаалын өмнө тал дугуйран зогссон үдэгсэд дотор морьтой, явган өвгөд хөгшид, үрээ дүүрч сундалсан, хөтөлж тэвэрсэн бүсгүйчүүд, хэдхэн жилийн дараа энэ л хөтөл дээр анхныхаа морин жагсаалд жагсах бэсрэг залуус байж байлаа. Охид сүрэг саалийнхаа завсар нулимсаа дундруулж амжсан бололтой, нэг хэсэгтээ нүд хуурай байцгаана. Эхчүүд, ёсыг сахиж, биеэ барьцгаана.

Сумын дарга би товчхон үг хэлж, социалист эх орноо хамгаалахдаа амь насаа үл хайрлахыг сануултал, эмсийн нэг нь ёсыг зөрчиж енгэнэтэл уйлж орхидог байна. Ингээд үдэгсэд дороо хавьчиж эхлэхэд байлдагчдын царай хувирч нэг бүрийн нүдэнд нулимс мэлтийгээд явчлаа. Би яаравчлан “Таван жил улиран өнгөрөхийн цагт таван хоногоос өөрцгүй санагдахын ёсон бий. Баяртай, байлдагчид аа!” гээд хөвгүүд рүү алхтал үдэгсэд ми ний хойноос ханаран дагалаа. Би байлдагчдын гарыг атгахдаа инээм сэглэн, эрс шийдэмгий байх юм шүү гэж дотроо бодсон билээ, гэтэл Баянактай харц тулгарахдаа сэтгэл хямран, толгой эргэх шиг болов. Хүү минь жагсаалын магнайд, тогтож ядан байгаа хүлгийнхээ жолоог энэхэн агшинд султган, гялхийн одоход бэлэн байгаа мэт дөрөөн дээрээ өндийсөн байв. Би өвдөгт нь хүрснээ ухасхийн, хүзүүдэж аваад ойртуулан татаж ирээд нүүр нүдгүй үнсэж гарсан бөгөөд ингэхдээ “Миний хүү!” гэж хашгирах шивнэхийн хооронд ахин дахин хэлж байж. Тавиад харвал Суяший минь нүдийг хуулсан дүрлэгэр хар нүдэнд нь нулимс мэлтэлзэн, тэр нулимсны цаана “Намайгаа хөөж туугагүй билүү, аав минь!?” гэсэн асуулт дүрэл зэн байв. Энэ үед өөрийн минь ч нүдийг нулимс бүрхээд ирэхийг мэдэн ичихдээ бушуухан дараагийн хүн рүү хүрч очоод түрүүчийн санам саргүй хийснээ одоо санаатайгаар давтав. Би байлдагчдыг бүгдийг хүзүүдэж, бүгдийг үнссэн боловч хэн дээр нь ч Баянактай зууралдсан шиг тийм удсангүй. Ингээд баахан хөл хөдөлгөөн болж байснаа буурал эхчүүд хултай сүүгээ идэр эр сэд амсуулан, унасан морьдынх нь дэл сүүл, тохсон эмээлийнх нь дөрөө юүгий нь мялааж дуустал хөдлөх тушаал өглөө. Нирхийн дуу эхэлж, цуваа хөдөллөө. Байлдагчид тэнгэрийн хаяанд уусан, агаарт дэгдсэн тос замхран алга болтол үдэгсэд тарсангүй. Тэр өдөр гайхалтай удаан өнгөрлөө. Би хонтоортоо байж сууж ядаад нар хэвийхийн үед хөдөө мордож, буусан хоносон айлдаа явсан байлдагчдын тухай бүгдийнх нь эцэг шиг ярьж явлаа.

Дайны үеийн тухай би чамд шинэ юм юу ярилтай билээ, ном сэлт өдий төдий гарлаа шүү дээ. Бидний нойр дутуу, ходоод дундуур, хүйтнийг хүй тэн гэлгүй, халууныг халуун гэлгүй зүтгэж, олсноо фронтод илгээж бай сан маань худлаа биш. Миний бие өөрийгөө ертөнцөд даанч чухал хүн гэж бодож явснаа эс оролцуулбал намын байлдагчид тэнцэхээр зүтгэсэн гэж хэлэх зүрхтэй байна.

Байлдагчдаас захиа занаа ирэх нь нэн ховор, олонхи нь бичиг үсэг мэдэхгүй ч байсан юм чинь. Тэгтэл хоёр дахь жил дүүрэхийн үед Баяна каас минь өөрийн гараар бичсэн захиа ирдэг юм байна. Миний баярласныг хэлээд яахав. “Уг нь ийм л байхаар сэргэлэн хүүсэн дээ!” гэж нулимс унаган байж өөртөө хэллээ. Гэтэл бас захиандаа юу бичсэн гэж санана. Ангидаа мэргэн буудагч, бага дарга болсон гэнэ! Би ч бүр хөл алдаж орхилоо. Үртэй хүний жаргал гэж ийм байдаг байж. Тэгээд хүүгий минь хугацаат алба дуусахад яг 1000 хоног дутуу байхад банзны зах олж ирж, харуулдаад дээр нь харандаагаар 10 эгнээ тус бүр 100 зураас зурж, өнөөх банзаа дэрэн дороо хийн, шөнө унтахаар хэвтэх болгондоо зурааснаас нэгийг баллуурдан арилгадаг боллоо. Заримдаа хөдөө явж ирээд зурааснаас нэг дор хэд хэдийг баллуурдаж байхад тун ч сэтгэл өег байдаг байв. Дайн дуусч, хүү минь эргээд ирсэн хойно ямаршуу янзтай аж төрөхөө бодоод байхад гайхалтай нь миний эдлээгүйг Баянак эдлэх учиртай болдог байв. Битүүхэндээ нутгийн охидыг шин жиж, гэрийн мод, тавил сэлт харж явдаг боллоо гээч. Дайны хатуу бас чиг юм бодогдуулж, эдгэрэх замдаа орж явсан минь ч тэр юм билүү! Амьтны ам хэлнээс айдаг минь урьдынхаараа ч зураас хорогдох тусам миний сэтгэлд нэгэнт сэрсэн эцгийн бахархал газар авч байлаа.

Дөчин гурван оны аравдугаар сард манай намын үүрийн дарга ууш гины хатгалгаагаар нас барсан нь сумын удирдлагад нэлээд өөрчлөлт орууллаа. Нас барсан нөхрийн оронд би, миний оронд аймгаас ирсэн нэг залуу оров. Тэр залуу насаар бол бага ч гэсэн сүрхий томоотой, тэр мөртлөө шаардлагатай үед нугаршгүй хатуу байж чаддаг хүн байв. Сумын хуучин орлогч өөр ажилд шилжиж, оронд нь Доёбуу бол лоо. Сумын даргын тушаалаас буух болсондоо би эхэндээ гомдлоо, учир нь ингэх юм гэж санаагүй явсан байлаа. Гэхдээ дараа нь “Нам гэдэг чинь хам гаас чухал болохлоор энэ ажилд надаас өөр тэнцчихээр хүн ч байх биш дээ” гэж бодохдоо тайтгарлаа.

Сумын шинэ даргын арга бари лыг хараад байтал өөрийнх минь чамлагдаж эхэллээ. Дал дуур биширч, бүр дуурайвч өнгөн дээрээ бүхнийг мэддэг хүний царай гарган, хийсэн хэлс ний нь өчүүхэн юман дээрээс өөлж шүүмжлэх гэж үздэг байлаа гээч! Миний түрээ барих зүйл бол туршлага, туршлагатай ахмад хүний хувьд өнөөхөд чинь зааж заавардаад л, ёстой усан тэнэгийн зан шүү дээ, залуу хүн чи мэдэж аваарай.

1945 оны наймдугаар сарын 23-ны өдөр халд варт өвчин гарсан сарлагийн суурь хүрэхээр Цагаан Асга руу явж байлаа. Гэтэл Арцатын Хамар даваан дээр гарч явтал хойноос минь зарлага гүйцэж ирээд сумын дарга одоохон замаас эргээд ир гэж байна гэлээ. Очвол сумын удирдах нөхөд даргын хонтоорт цугларчихсан байж байв. Дарга дэлгээстэй цаас барьчихсан өөдөөс минь хүрч ирээд “Ийм юм болжээ” гэсэнд өнөөхий нь авч уншиж эхэлснээ давхийтэл цочоод дахин эхнээс нь уншив. Хэд дахин уншсанаа, дараа нь юу хэлснээ, яаснаа мэдэхгүй байна. Бодвол өнөө бичгийг сумын даргад буцааж өгөө биз. Нүдий минь гэнэт асар олон улаан, ногоон тойрог хаагаад тэр нэл улаан, ногооны дотроос гагцхүү арилшгүй хар үсгүүд цувран гарч ирэх нь бодоод байхад ...Баянак оргосон... даруй баривчлах... эсэргүүцвэл буудах... гэсэн санааг бү тээж байв. Үүний цаана “Адилхан нөхөд нь цусаа урсган тулалдаж байхад нэг нь амиа хоохойлон оргож зугтаж явах ч гэж дээ. Нутаг усныхны маань нэ рэнд яасан ч муухай юм бэ! Чамайг муу нохойг би өөрийн гараар буудан алья!” гэж нэг хүн гаслах нь дуулдана, Доёбуу...”

Жанибек шанаагаа базлан дуугүй сууна. Оёд лоороо ханзарсан хурган малгайн дороос цухуйх цав цагаан үсэнд шигдсэн бахим хуруунууды нь харахад хөх асгыг өрөмдөн ургасан зуун наст хар модны дээрээсээ нүц гэрсэн үндэс санагдана. Цас хаялж эхэл лээ.

“Зургаан хүнтэй салаа байгуулагдаж, хүн бү рийг 30 сумтай карабин буугаар зэвсэглэлээ, за хирагчаар нь намайг та вих боллоо.

Тэр жил урт зун боллоо. Есдүгээр сарын арав даар сумын төвийн урьдах тал бас л ногоо ноороо. Шувуу буцах цагаасаа бүтэн сараар оройтлоо. Эх ний айлууд бүр сарын хуучдаар сая л Цагаанголын дэлгэр хөндийд орж ирлээ. Дайн ялалтаар дуусч, ялагчдыг хүлээж байв. Унах морьды нь аль эрт барьж ирээд, аргамжны үзүүрт сойн, нүүхэд ч нуруунд нь эмээл хүргэж эс түвдэн, хүлээсэн эзнийх нь эцэг, аль эсвэл ах юм уу дүү сул хөтлөн явна. “Хүрээд иржээ” гэсэн үг хэдийд л дуулдах бол гэхээс уул, ус хүртэл чих тавин чагнаж байх мэт.

Баянакийг хүлэг морь нь бус, сумтай буу, даалгавартай эрс, шийтгэл хүлээж, тэр шийтгэл нь үхэл гэсэн үг ч байж мэдэх байв. Гэхдээ чухам юу болсныг бид мэдээгүй л байлаа.

Намрын шөнийг нүд хараастай өн гөрүүлдэг болов би. Харанхуй тэр чигээрээ Баянакийн нулимс мэл тэлзсэн нүд болж хувирна. Таван жил нэгэнт улиран өнгөрөөд таван хоногоос өөрцгүй санагдана. Өөдөөс минь ширтэх нулимс дүүрсэн нүдийг харж хэвтэхдээ, “Аавдаа юунд ийм хэрэг хийв, хүү минь?” гэж санаандаа асууна. Заримдаа үнэхээр шивнэж орхиод өөрийнхөө дууг сонсохдоо нулимсаа барьж эс дийлнэ.

Аравдугаар сарын 29-нөөс 30-нд шилжих шөнөсөн. Аанай л нойргүй хэвтэж байтал үүдэнд хөлийн чимээ гарах шиг боллоо. Нохой бол яваад өнгөрөх учиртай гэж би бодлоо. Учир нь үүд хавиа би дөнгөж өмнөх орой нь цэвэрлэсэн байсан билээ. Чив чимээгүй болчихлоор нь өөрийгөө андуурч дээ гэж бодовч хэвтээд байж болсонгүй, эвтэйхэн босч хаалга хү рээд чихээ ойртуулан чагналаа. Юу ч эс мэдэгдэв. Тэгэвч ор руугаа явах тэнхэл байсангүй, хаалгаа онгойлгоод өрөөсөн хөлөө босгон дээгүүр да вуул тал байшинтай чацуу өндөр хүн туур ганд наалдан зогсч байгааг харахдаа аяархан дуу алдчихлаа. Айхтар харан хуй шөнө билээ, тэгэвч зүрх минь Баянакийг таньчихжээ. Хаалгаа угз та тан хаагаад түгжих юм уу, гүйж ороод галтай буугаа шүүрээд ирэхийн оронд ухасхийн хүрч хүүгээ тэврэн аваад аль тааралдсан газры нь үнсч үнэрлэж, гарахдаа енгэнэтэл уйлж байж. Энэ бол баярласных байлаа. Учир нь ганцаардлын бэрхийг ясанд минь хүртэл мэдрүүлсэн энэ голгүй харанхуй шөнө ханьтай болж, тэр нь зуун гол, мянган уулыг туулан, алхам бүрт гэтэж байсан аюулыг ялан ялсаар төрсөн Алтайдаа хүрч ирсэн, яснаас минь хугарсан яс, махнаас минь тасарсан мах-миний үр байлаа. Намайг хөндийрөхөд хүү минь хөшчихсэн юм шиг зогсч хоцорсноо “Дуулаа биз дээ?” гэж сулхан хэллээ. Би түүнд ха риу хэлэхийн оронд бушуухан татаж оруулаад, хаалгаа хааж, дэн асаав. Зөн совин гэгч нь тэр үү? Урьд тэгдэггүй би тэр орой таваг дүүрэн мах чанажээ, аваад урд нь тавьж өглөө. Бас данхтай хүйтэн цайнаас мэлтэлзтэл аягалж гарт нь бариуллаа. Энэ бүхэн нүд ирмэхийн зуур л болж өнгөрсөн хэрэг.

Цонхонд шил байгаагүй, тугалын илгэ татдаг байсан цаг. Хаалга түг жээтэй, би үүд хоймрын дунд зогсч байлаа. Баянак тавагтай махан дээ гүүр тонгойчихсон, гартаа аль тааралдсанаас нь тас тас татан амандаа чихээд хир хир зажлах нь ган шүдээрээ харгана тээрэмдэх залуу тэмээг санагдуулна. Биенд нь ихэд жижигдсэн, энгэр су гаараа ханзарсан хөвөнтэй тэрлэг

өмс чээ. Хаанаас хулгайлаа бол? гэж бодохдоо зүрх минь эмзэглэн өв дөж байлаа. Морь малын хөлөөс тайлж авсан бололтой хорчгор сур бүсэлжээ. Түрий нь шинээрээ бахиал гутлынх нь ул мөлчийтлөө элэгдэж хадаасаараа ханзарсныг төмөр утсаар томж торгожээ. Толгойдоо алчуур зангиджээ, дороос нь цухуйсан үс магнай, захы нь бүрхэн унжиж байв. Нар салхинд онгосон, эцэнхий нүүрэн дээгүүр нь ядарч туйлдсаны шинжийг илтгэх зэвхий туяа татна. Омголтсон уруулынх нь энд тэндээс цус гарах боловч анзаарсан шинж алга.

Баянакийн захлах эрч нь намдах тусам ми ний сэтгэл түгшиж эхэллээ. Түрүүчийн баяр арилсан байлаа. Орон дээгүүр минь сумтай буу өлгөөстэй, эх орны өмнө гэмтэн болсон, гагцхүү тийм гэж итгэхэд даанч бэрх эцэж туйлдсан царайтай, төрсөн нутгаа тэмүүлэн гүйж ирсэн үлгэр судрын аргамгийг санагдуулам энэ хүний хувь заяаг үүр цайхаас өмнө шийдэх ёстой байлаа. Баянак цадав бололтой. Би зогссон чигээрээ “За хө” гэлээ. Толгой нь гудайсхийв. Би авдар онгичин хайрцаг янжуур гаргаж ирээд өвөр дээр нь тавилаа.

Баянак тамхинд халж хүрч чадахгүй байгаа бололтой, гар нь салгална. “Тал хайрцагтай гар сан юм. Сүүлчийн удаа утаа сорсноос нааш 49 хонож байна” гэснээ тамхинд хүрч, хайрцгий нь ханз татан нэгийг авч амандаа зуугаад дэнд ойртуулан асаалаа. Эхэндээ хахаж ханиалган, том том хөлсөн дусал ша наанд нь бурзайн гарч ирлээ.

“Дөчин дөрвөн оны намар манай дарга урд хилд шилжлээ” гэж ярьж эхлэх нь тэр. “Орных нь хүн ч ирлээ. Ганцаараа ч биш дагуулсан нэг бүс гүйтэй юм. Эхэндээ охиныг нь л юм байх гэж бодож байлаа. Тэгэхнээ хо жим дуулбал эх нэр нь юмсанж. Цэрэг харахаас тушаах, тулгах юмаа олж ядан байдаг офицерын авгай нар бай даг. Саяын ирдэг бол тэд нартай төсгүй, өөр ертөнцөөс ирсэн юм шиг сайхан, чухамдаа хүүх дээрээ амьтан юм.

Өдөр шөнөгүй байлдааны сургууль хийгээд цэргүүдийн ядрах гэгч жигтэйхэн, завсарлагаа зарлав уу үгүй юу налайтал унаад, дорхноо нам унтаад өгнө. Харин өнөө бүсгүйн барааг харж, дууг сонсч байхад тэгэх хүн ер үл гарна. Юунаас ингэдгийг мянган өдөр, мянган шөнө хөдөө хөхөрч, гадаа ган даж явсан дан эрчүүдийн дунд гэнэт эмэгтэй хүн орж ирнэ гэгч юу болохыг гагцхүү нүдээр үзэж, биеэр мэдэрсэн хүн л ойлгох биз.

Цэргийн хуаран гэнэт эцгийн гэр мэт дотно санагдаж, хэн хүнгүй дотроо нэг л нууцгай баяр агуулж явах шиг харагддаг болчихлоо. Тэгэхдээ Тунсагийн-нэр нь ийм юм-тухайд бол нууцаа хадгалах хүн даанч үгүй. Нууц ч гэж дээ, уг нь хамгийн эгэл зүйлс л дээ. Тунсагтай хаа, яаж яваад тааралдсан, юу гэж асуухад нь юу гэж хариулсан, ингэхдээ царай, нүд, дуунд нь ямар өөрчлөлт гарсныг нэгд нэгэнгүй мэдээлнэ. Ингэж ярихдаа түүнийг хүн болгон өөртэйгөө л хамгийн дотно болгож дүрслэхийг хичээнэ. Тэндэхийн хавар манай эндэхийнхээс өөр, сав л хийвэл элсээр шуурч, заримдаа хэдэн өдөр шөнөөр тэнгэр газар үл ялгарна. Зун нь элс улайстал халж, тэнгэрээс хааяа хэдэн дусал унавч газарт хүрэхээс өмнө ууршин алга болоод өгнө. Ийм цагаар нутаг улам санагдан, сэрүүн Алтай, түүний цаст цагаан өвлийн тухай яриад байх дур хүрнэ. Тайгын охин Тунсаг хөх нуур, ногоон зун, цаа бугынхаа тухай ярихад нүдэнд нь нулимс дүүрээд ирнэ. Баян хамаатнаа бараадан амь зууж явсан өнчин охин санамсаргүй учралаар цэргийн даргын эхнэр болж энд ирсэн хойноо нутгаа санан, харихын хүслэнд автавч авааль эрийнхээ өөдөөс ам ангайж эс зүрхлэх ажээ. Цаадах нь дуугүй, яггүй чанга эр. Тунсагийг нар гэвэл тэрээр чухамдаа үүл мөн байлаа. Явсан газар нь аниргүй нам гүмд умбаж, ойртсон бүхэн нь бүүдийгээд явчих шиг санагдана. Түүний өмнө зогсохдоо ямар ч

нэрд гарсан бөх зүрхтний магнайд нь заавал хүйтэн хөлс дааварлаад ирнэ. Эхнэрээ зоддог байв. Энэ тухай Тунсаг үг алдах нь үгүй ч цэргүүд яаж ийгээд л мэдчихнэ. Ер нь хавьтсан болгонтой хардана, орлогчийнх нь хувьд гэр орноор нь хамгийн олон орж гардаг байсан болохлоор надтай бүр ч их харддаг байсан биз. Тунсагаас болж харахаас дургүй хүрэвч даргын хувьд би түүнийг гайхан биширдэг байсны учир гэвэл цэргийн эрдэмд төгс, тэвчээр, зориг гэж ёстой л ган шиг эр, тэр мөртлөө одон тэмдэг зүүх, урьдынхаа гавъяаны тухай ярих гэгчийг мэдэхгүй. Гучин есөн оны дайнд хэдэнтээ шархдан тоогүй олон япон устгасныг нь дуулсан юм чинь бид.

Шийдвэрлэх мөч тулж ирээд байлаа. Найм дугаар сарын 3-нд дарга штабт дуудагдан очоод орой буцаж ирэв. Тэгээд л шөнөдөө манай анги дорныг чиглэсэн аяндаа гарч, үүр цайхад 280 км зам туулсан байлаа. Хаашаа л харсан морин цэрэг, танк, машины цуваа, бүгд л дорнын чигт. Тэгтэл зогсч, үдшийг хүлээх тушаал ирлээ. Тунсаг дэргэдүүр өнгөрөхдөө ингэж шивэгнэдэг юм байна. “Цаадах чинь намайг замд хамаатнууд дээрээ орхих юм байна. Тэгж танихгүй нутагт хаягдахаар хот орж, тэндээсээ цааш харья. Чи надад тусална шүү, Баянак!” Тэгээд хариу хэлэхийн завдалгүй яваад өглөө. Үдэш боллоо. Хөдлөх мөчөө хүлээн зогсоо нүргэлсэн цуваан доор газар дэлхий донслон чичирч, хавирган сар тэнгэрийн хаяаг шүргэн алдана. Дарга, Тунсаг бид гурав нэг тэргэнд сууж байв. Тэгтэл өнөөх чинь бие засах хүний дүр үзүүлэн буугаад шулуухан алхсаар нэг харганы араар ороод явчихдаг юм байна. Гар хоосон бүсгүй харанхуй шөнө эзгүй талд чоно нохойн идэш болох нь гарцаагүй тул холдчихоос нь өмнө буцааж авчрах хэрэгтэй байлаа. Гэтэл яаж буух вэ? Хэсэг бодсоноо ийм арга оллоо. Юмаа гээсэн хүний дүр үзүүлэхээр өвөр, халаас, түрийгээ хэсэг уудалж, тэмтэрснээ үсрээд буучихлаа. Тэн гэ рийн ирмэгийг шүргэсэн сар, нүр гэлсэн тал, айх гэж тоймгүй.

Тунсаг ердөө холдоогүй, харганы сүүдэрт хярсан болжмор шиг нугдайн сууж байв. Айсан дүрлэгэр нүдий нь хараад туслахгүй байж чадахгүйгээ мэд лээ. Гар буугаа тайлж гарт нь атгуулж өгөөд “Алтан гадсыг л алдалгүй яваад бай. Үүр цайж, нар гарахад зэвсгээ хаяарай. Тэгээд өдөржин явахад хүн, малын бараа харах бий гэлээ. Тунсаг намайг тэврэн авснаа “Ачий чинь хэзээ ч мартахгүй” гэж цорхирон өгүүллээ. Тэврээс нь мултраад эргэтэл ард минь дарга зогсч байв. Гарт нь чинжаал гялалзана. Өрсөж бугуйн дээрээс нь шүүрч авлаа. Гуд татах гэсэн чинь барсангүй. Харин өөрийг минь өсгийдөж орхиж. Унахдаа бугуйгий нь тавьсангүй, часхийн хадах Тунсагийн дууг сонслоо.

Газар шүргэсэн сар, наана нь чинжаалын хурц үзүүр. Дор нь миний багалзуур байлаа. Тэгтэл би хүлээвэл зайлшгүй дийлдэхээ ойлгон ахин өрсөж үзэхээр шийдэн зүүн гараа суллангуут багалзуур дээрээс нь ухасхийн атгаад авлаа. Нилээд ноцолдсоны эцэст өнөөх ургаа хад, унасан харгай шиг дээрээс няц дарчих гээд байсан гар эхлээд байрандаа хөшиж, дараа нь хуруу хуруугаар буцаж эхлэх нь мэдэгдлээ. Би ч тулснаараа тулаад, базсанаараа базаад байтал яваандаа бүр суларч мэдээ алдран хажуу руу минь гулсан ойчоод ирлээ. Босч ирээд би Тунсагт “Цаадуулдаа хэл өг!” гэлээ. Гэтэл өнөөх чинь орь дуу тавьж цаашаа гүйхийн оронд түрүүхэн өөрт нь өгсөн гар бугуй минь буцаан өгч, “Бушуухан зугтаж амь гарахаа бод!” гэх нь тэр. Би буугаа авсан боловч байрнаасаа хөдлөлгүй зогстол дарга хөдөлж, толгой нь өндийж ирснээ, хахирган дуугаар, “Дайны талбарт хүрээгүй байж үхэх аз муутай амьтан юм даа, чи!” гэлээ.

Би гүйчихлээ. Саргүй цэлмэг шөнө. Алтан гадсаар чиг барьж, гүйж гүйж нэг хэсэг алхаж амьсгаагаа дарж аваад л аанай гүйсээр. Үүр цайх үеэр бутан доогуур шургаж элсээр биеэ булаад хэвтчихлээ”.

Баянак яриагаа дуусгаж, шинээр янжуур асаав. Тийм байж, арай ч хүн алаагүй юм шив дээ гэж сэтгэл бяцхан амсхийн бодлоо. Гэтэл дайны хүнд цагаар цэргээс оргосон хүнд хамгийн ха туу шийтгэл оногдох нь илэрхий гэсэн бодол дөнгөж амсхийж, зай гэгээ гарч эхэлж байсан сэтгэлийн мухрыг харанхуйлан эзлээд авлаа. “Цаад дарга чинь чамайг зүгээр үлдээх ч үгүй байсан. Гэхдээ чи оргож зугтах хэрэггүй л байж. Оргосон учраас л хэлтрүүлэхийн аргагүй буруутан бол жээ” гэвэл Баянак “Тиймээ, одоо гагцхүү баригдахгүй байх л байна” гээд санаа алдав. “Үгүй” гэж би ширүүн дуугараад, “Хөдлөхгүй суухыг сануулъя. Чамайг баривчлах даалгаврыг надад намаас хүлээлгэсэн юм” гэлээ. Баянак босон харайгаад хаалга руу ухасхийсэн боловч би түүнээс өрсөн хананд өлгөөтэй байсан буюу шүүрч аваад араас нь чиглүүлж “Зогс! Буудлаа шүү!” гэж хашгирав.

Өтөл нөхөр минь сүүлчийн үгийг нээрээ л хашгирч хэлсэн тул хоолой нь зангирснаа дараа нь таг болчихов. Гал руу ширтэн гөлөрсөн нүдэнд нь бяцхан цэгээн нулимс гялсхийв. Тэгээд л дарж орхиж дээ, битгий л цаашаа яриасай гэж бодохдоо “Цас орж байна” гэлээ. Гэтэл өвгөн юу хэлснийг минь ойлгосон, тэр ч байтугай сонссон ч шинжгүй яриагаа үргэлжлүүлээ. “Баянак зогтусч эргэж харахад царай нь бүр зэвхий даачихсан байлаа. “Яаж зүдэрч яваад хүрч ирс нийг минь мэдэж байна уу, аав аа?” гэж бууны голыг дагуулан харж хэлэв. “Өдөржин нуугдаад шөнөжин явах гэгчийг! Далан хоёр өдөр, далан хоёр шөнө гээч! Нэг өдрийн хичнээн уртыг, нэг шөнийн хичнээн богиныг, чулууны хатууг, элсний халууныг та мэдэхгүй! Хичнээн олон шөнө зүг чигээ алдаж, нүд минь од харахын, нүүр минь салхи мэдрэхийн хүслэн болж явахдаа, хичнээн их айж, гутарч үзвээ, би! Тэгсээр арай гэж нэг угаасан голынхоо усыг амтлахдаа, унасан нутгийнхаа шороог үнэрлэхдээ хичнээн их баярлав аа би!

Тэгээд тантай учрахдаа! Тиймээ, танаас хэдий айсан ч, орчлон дээр харж хандах ор ганц хүнээ гэж тэ мүүлэн хүрч ирсэн билээ би. Эцгийн зүсийг харж, дууг сонсов. Цаана нь бас эхийн булшийг олж, үнэрийг эрмээр, уултайгийн хэрэг юу билээ, оройд нь гарч талаа хармаар, антайгий нь хэрэг юу билээ, угалзы нь унагаж, тэхий нь намнамаар, өссөн газрынхаа өвсөнд нь хөлбөрч, шороонд нь тонгочимоор, өөрийн тэнгэрийн салхийг амталж, одыг тоолмоор, зуны бороонд нь шалба цохиулж навч цэцэгтэй цуг нарыг хүсмээр, өвлийн цасанд нэвс даруулж, туурайтан жигүүртэнтэй цуг хаврыг хүлээмээр санж! Ашиг хайсан урвагч биш, амь бүрэлгэсэн алуурч биш, гагцхүү хүчинд хоригдсон хүний алаг үрд тус болох гэж яваад эндсэн, эндсэний эцэст эх орны даалгавар, эр цэргийн албанаас биш, оногдох ялаас, отох үхлээс зугтсан билээ би!”... Цаашаа ярьж чадалгүй уйлж гарлаа. Нэг талаас үүрэг, нөгөө талаас хүү минь намайг хоёр тийш чангаасаар эцэст хүү минь дийллээ. Буюу хаяад Баянакийг үнсч “Яв даа, гэхдээ л хуулиас мултрах зам байдаггүй юм даа, бор туулай минь” гэлээ.

Цэргүүд ирж, найр их боллоо. Цас гүй жиг тэйхэн намар болов. Хяруу унаж хоновч нар хөөр мөгц төдхөн хайлж алга болоод өдөржин баруун хой ноос үлээх өнөөх л зөөлөн хонгор салхи. Тэнгэрийн хаяа өдрөөс өдөрт улам л өргөжин тэлэх мэт цэлийн холд соор.

Оргодлын тухай албан бичиг ол ширч, энэ ч сумын, тэр ч багийн нутагт сэжиг бүхий хүн харагдсан гэх цуу яриа ч газар ававч түүнийг яг зүсээр нь таньсан баримт алга л байв. Зарим хүн дуулсан бүгддээ итгэсээр байгаад гэгээн цагаан өдрөөр ч гадуур явахаас айж, бүрэнхий болмогц хаалга үүдээ янгинатал хүлээд суудаг болж байхад, нөгөө зарим нь хэдэн арван агт морь сольж унасан хэр нь бүтэн сар явж хүрдэг алсаас явган нүцгэн ирчих хүн гэж байхгүй, тэгээд ч ер нь оргосон хүн аль болохоор л хүн танихгүй нутгийг тэмүүлэх нь зүй гээд юу ч дуулсан үл хэрэгсэнэ. Би эдгээр ярианы алинд ч эс оролцон, харин амьдралдаа анх удаа намаа хуурсандаа бантан явдаг байв. Орой нь гялалзаж, бэл нь шаргалтах уулсыг харахдаа хүүгээ санан, чухам хаахна нь яваа бол гэж заримдаа баяр лан, заримдаа гутран бодно. Бас хор буцлан, чамаас л болж би намаа хуурахад хүрэв гэж бодох үе ч байдаг байв.

Арван нэгдүгээр сарын дундуур аймагт дуу дагдлаа. Хэдэн өртөө газ рыг туулахдаа яаравч урьдынх ши гээ давхисангүй, бас өртөөний то гооч, агтчидаас хэний нь ч зандарч загнасангүй. Бодсоор явтал өнгөрснөөс ичих шиг, ирээдүйгээс айх шиг болно. “Оргодлыг өнөө хүртэл яагаад барьж авахгүй байна?” гэсэн аймгийн нөхдийн асуултанд “Хүрч очоогүй оргодлыг яаж барих билээ?” гэхчээ нүүрнээс минь гал гарах шиг болов. “Хүрч очихоор барах уу, эрх таваараа явж байгаагий нь бид мэдэж байна. Нэгийгээ нөгөө нь нотолсон мэдээ танай сумын ардуудаас ирсэн. Гэтэл зэр зэвсэглэж, барих даалгавар өгсөн хүмүүс, бүр хэсгийн дарга нь өөрөө юу ч мэдээгүй явж байдаг! Өөр нэгнийг бодвол барьж өгөх дургүйдээ тэгж байна гэж ч бодож болох байж. Танд бол нөхөр Жанибек бид даанч итгэдэг” гэсний нь яана. Надад дуугарах тэнхэл байсангүй. Гурван долоон хоногийн хугацаа өглөө. Төв газрын амьдралыг харж явахдаа анх удаа өөрийгөө чамлах сэтгэл төрөн, чиний л амьдрах цаг үе юмсан даа, хүү минь гэж сэтгэл хөндүүрлэн бодлоо.

Буцаад ирэхэд уул, талгүй цав цайрчихсан байв. Баянгийн даваа, Те рек тийн нурууг харахдаа дотроо ийнхүү халаглалаа. Хувцас нимгэнтэй, осгочихсон байх вий! За тэгээд хүйт нийг дававч биднээс мултрах биш дээ...

Маргааш өглөө нь зэр зэвсэглэсэн зургаан морьтон Баянакийг барихаар сумын төвөөс хөдөл лөө. Хойд нурууны зүүн суганаас эхлэн хотгор гүдгэрийг нэгд нэгэнгүй самнахаар бол лоо. Салхи гараагүй тул цас зөв зөөлхнөөрөө, мөр үлдээхгүй явахын аргагүй байв. Тэнгэр тэртээ өндөрт, хав хар хөх, хүйтэн, агаар тув тунгалаг, үнэг нүүдлийн газраас дуранд торойно. Нэгийгээ нө гөө нь нотолсон мэдээнд надаас өөр ч итгэсэн амьтан үгүй бололтой. Доёбуу бол бүр ч үгүй. “Тэр муу нохой одоо хүртэл яаж амьд байх юм бэ? Ингэж ч цуу ярианд итгэж, хий дэмий ажлаа алдах гэж дээ! гэж гасална. Ар гэртээ санаа зовсон нь илт, нударган авгай нь гав ганцаар үлдчихээд байсан юм чинь. Буу дуугаргах нь хориотой бөгөөд үүнд л угийн анчин эрсийн сэтгэл юу юунаас илүү гонсойж байх төлөвтэй. Учир нь цасан дээгүүр сүлжилдэх ан араатны мөр их, чоно үнэг мэтэс урдуур харайлдахад тэд юу ч анзаараагүй мэт царай гаргавч яг далд орохын тэнд тэсэлгүй уруулаа хазаад авах нь үзэгдэнэ. Үдэш болоход, аль биднийг хүүхэд байхаас л нааш нэр ус нь дуулдаад байдаг байсан нэгэн хэлгүй хөгшний агуйд хүрч ирэв. Ардын засаг хэдэн мал өгч, сумын төвд ирж лам нарын үлдээсэн бяцхан дүнзэн байшингийн нэгэнд суурьшин сууна уу гэсэнд малы нь авсан хэрнээ ан аваар аж төрдөг тул агуйдаа байснаараа л байя даа гээд хөдөлж өгөөгүй, хожим харин тэндээ ч биш, бүр эмнэлэгт ирж нас барсан тийм нэгэн сонин хүн байж билээ, зайлуул. Доёбуу түүнтэй дохио зангаагаар “ярьж” гарав. Эх лээд эрхийгээр өөрийгөө зааснаа дараа нь чигчийгээ

харуулангаа до лоовор хуруугаа хам рынхаа урдуур хөндөлсүүлэн, бас нүд рүүгээ заагаад асуусан байдалтай өөдөөс нь харав. Энэ нь “Миний хүүг харсан уу?” гэсэн асуулт байлаа. Цаадах нь толгой сэгсрэв. Ингээд бидэнд түүн тэй ярих өөр зүйл байсангүй. Гурав маань агуйд, үлдсэн гурав маань агуйн эзэнтэй гадаа унтахаар болов. Од ярайсан, од бутарсан шөнө, хад хагарах, тасрах мэт чимээ хулхин дороос нүргэлэн дуулдах нь орчлон дэлхий царцаж байгааг илтгэнэ. Нулимс дэрэн дээр унахын хооронд хөлдөн, эргээд хацар хайрах нь мөсөн тэвнээс өөрцгүй. Жавар үүрээр бүр ширүүсэн агаар тэр аяараа мөс болчихоод дээрээс дарж байх мэт санагдана.

Намрын шувтаргын тэр шөнө од цас хоёрын завсар унтаж хоносон ганц хүн бол хэлгүй өвгөн байлаа. Дараачийн шөнийг бас л юу ч үзээгүй гэх адуучны хошид өнгөрөөлөө. Тэсэл гүй шөнө дөлөөр нэг маань босч гал түлсэн санагдана. Хүйтний эрч цагаар чангарч байлаа. Хара-даг, Теректиг, Баян, Талдыг, Булуктугийг нэлд нь самнасан боловч мөр олсонгүй. Дэмий юмны төлөө ажил алдлаа гэх хэл ам улам улмаар газар авч, зарим нь ч шууд буцъя гэсэнд би, “Энэ сумын нутаг дээр бидний яваагүй нэг л уул байсан цагт буцах тухай ярихгүй шүү!” гэ лээ. Үүнийг дуулсан нэг нь тэсэлгүй “Тэгэхэд хүр вэл дор хаяад арав хононо гэсэн үг болох нь ээ!” гэж дуу алдсанд, “Яадаг юм! Хорь хоногийн хугацаа бидэнд байна!” гэж би хорь нь маажин хариуллаа. Нээрээ ч, Баянакийг олоогүй цагт буцахгүй гэж бүр шийдчихээд явсан билээ. Учир нь өвлийн хүйтэн гэдэг бол төрийн хуу лиас ч хатуу зүйл шиг санагдах нь олохгүй бай саар ес эхлүүлчих юм бол остож үхэхээс зайлахгүй, харин бариад авчих юм бол амий нь өршөөж ч юу магад гэж бодсоных билээ. Ахин дуу гарах хүн гарсангүй. Бүгд зай зайгаа барин уулын оройгоос бэл хүртэл тарчихсан хоёр тийшээгээ ээлжлэн харуулдсаар нэгэн хэмээр урагшилсаар байлаа. Ийм эрлийн замаас бултах арга мөртэй, бараатай хүнд үгүй нь илэрхий билээ. Баянакийг олно гэдэгт итгэн, тэгээд ч тушаалгүйгээр буудах хориотойг, буудах ту шаалыг гагцхүү аминд халтай эсэргүүцэлтэй тулгарахад хүрвэл сая л өгнө гэдгийг ахин дахин сануулсаар явлаа. Таван Богдын бараа тодорсоор байлаа. Чө мөг царцаам хүйтэн салхи үлээнэ. Даарах гэж ч тоймгүй. Голд минь хүйт нэвтрэх тусам яаран бачимдаж, барьж авалгүй явуулчихсандаа гэмшинэ.

Дөрөв дэх өдрийн үд хавьд юм сан. Бэлд яв сан хүн маань дууддаг юм байна. Миний бие дээрээсээ хоёр дугаарт явсан боловч хамгийн түрүү лээд дэргэд нь хүрчихжээ. Унасан морь минь цастай өндрийн уруу мөсөн дээр алдуурсан чарга шиг шуугин буужээ. Боож багласан ултай савхин гутлын мөрийг үзээд зүрх минь амаар гарчих шахав. Амьд яваа юм байна! гэж баярлан бодтол хажуугаар нь бас, авай бор туулай минь хавраа хүлээж чадсангүй дээ! гэсэн өөр нэгэн бодол цээжинд төрөн нармайн угаар шархираад ирлээ. Мөрийг ажиглавал тун удаагүй, үүрээр гарсан болов уу гэмээр, уулнаас бугаад тал руу одсон байв. Эрчүүд бүр гайхаж цоччихсон зогсох бөгөөд нүүрэн дээр нь хүнд аливаа барианы өмнө тохиолддог айдас, баяр хосолсон харагдана. Давхиагаар гартал морьд маань мө чийн дотор нэл цагаан цан болж, мөс шаргиж эхэллээ. Өвөл байтугай, зун ингэж давхидаггүй юм чинь. Хожмын хов яриаг бодоход зарим нь намайг алах хүчирхийлэх дуртайдаа л ингэж явна гэж санасан юм байлгүй.

Мөр Цагаанголыг гаталж, Хара-Хоовыг давж, Оруктуг руу орлоо. Орук тугаас эхэлж хатируулах, заримдаа бүр шогшуулахаас цаашгүй болсон маань нэгд зам муудаж, хоёрт морь эцсэнийх билээ. Баянак юунд энэ холын замд гарах болов? гэж бодоод бодоод олохгүй явлаа.

Хүйтнээс болоо гүй нь лавтай, учир нь Хойд нуруу шиг нөмөртэй газрыг хаанаас ч эс олох билээ. Хоол унд нь дуусчихлаа гэж бодоход айл, амьтантай газар ба раадмаар, Гэтэл явсан мөрий нь харахад аль л зэлүүд газрыг тэмүүл-сээр бүр зуслан руу одсон байх юм. Одоо тэнд отрын адуучдаас өөр хэн ч байхгүй байгаа. Гэнэт учры нь олох шиг боллоо. Биднийг харчихжээ! Тэн гэр өдрөөс өдөрт хөхрөн, агаар улам ч тунгалаг болж байсан тул энэ дун цагаан цасан дээр зургаан морьтон гэдэг чинь хоногийн газраас харагдалгүй хаа зайлах билээ. Урьд өдөр биднийг хараад шөнө болмогц тал дундуур гараад зугтжээ. Миний таамаглал үнэн бол тэр нь ядарсан арга байлаа. Цаашилтал мөр гэнэт Хара-Адырын чигт өгсүүр өөд хөтөл лөө. Хара-Адырын орой, хажуу нь шаазан шиг мөлийн цавцайх бөгөөд тэнд хүний урамд бүр тийх ч мөр гараагүй нь тээр үдийн газраас ив илхэн, хавцал нь харин тарлантан харагдах нь тэнд адуу бэлчсэнийг илтгэнэ. Мөр яван явсаар хавцал хүрээд алга болчихлоо. Учир нь адууны хөлд дагтаршин, нойтон хомоолтой барьцалдан хөлдсөн цасан дээр нэг байтугай хэдэн арван хүн ч мөрөө үлдээлгүй явж болох ажээ. Тэгээд ч Баянак ийшээ ирсэн биз. Гэтэл адуу бэлчиж өнгөрсөн мөр түүний замд тийм санаснаар нь элбэг тааралдаж өгсөнгүй, ганц олодохдоо очиж очиж эргээд гарах замгүй ханан хавцал руу хөтлөөд оруулчихдаг байна. Хөөрхий минь, урьд өмнө Хара-Адырт ирж үзээгүй байснаас зайлахгүй даг.

Хавцлаар өгсөх тутам улам уйтрав. Хоёр мө сөн хананы завсраас сунгасан хадаг шиг нарийн хөх тэнгэр тэртээ өндөрт зурайна. Адуу харин байсангүй, мөр сэлтийг харахад тун саяхан явсан нь илт. Өнөөх чинь, Баянак! Хэн түрүүлээд олж харсныг мэдэхгүй, ту шаал өгөөгүй байхад нэгэн дуугаар нирхийтэл хашгирсныг бодоход бүг дээрээ зэрэг л харсан болов уу. Баянак харин эргэж харсан ч үгүй, хэд сүрхий харайгаад нэг өнчин хадны цаагуур орчихлоо. Нөхдийн ца райг харвал зэв хийж барайчихсан, дуугарах тэнхэлтэй хүн ч үгүй бололтой. Доёбуу л харин элгэнд юм өвдлөө гэж гиншин ард хоцров. Хав цал шувтарч, тэнгэр хааж дээрээс өнгийсөн эгц халил өөдөөс тулаад ирлээ. Цасан дотроос энд тэнд хадны шовх үзүүр харлан цухуйна.

Баянак зогссонгүй, хөлдүү цасан дээгүүр дөр вөн хөллөсөөр авирч гар лаа. Байн байн хальтран элгээрээ унаад доошоо гулсавч маажиж савард саар тогтож авмагцаа ахиад л дөрвөн хөллөн урагшаа мөлхөнө. Хойноос нь “Алив чи болиоч! Хийсч үхэх нь байна!” гэж хэдэнтээ хашгирч үзсэн боловч өнөөх чинь дуулсан ч шинжгүй зууралдан авирсаар байлаа. Аргаа барахдаа замы нь тосуулан гал нээлгэлээ. Буун дуу уй тан хавцалд чих дөжрөм нижигнэж, эмтэрсэн цас, бутарсан мөс дээрээс нүүр нүдгүй урсав. Баянак цасанд наалдан хэвтсэн боловч буун дуу зогсмогц аанаа л авирсаар, би гэдэг хүн “Болно, Баянак! Буугаад ир! Чиний амийг бид хуулийн өмнө даана!” гэж ч хүртэл хашгирч үзлээ. Юу гэснээ ухаарах тэнхэл тэрхэн үед өөрт байгаагүй юм байх. Өнөөхийг чинь харж зогсоно гэдэг сэтгэлийн там байлаа. Өчүүхэн л эндэх юм бол, зуурсан мөснөөсөө хавх үсэрч, ямар ч бурхан, ямар ч доктор ирээд нэмэргүй юм болох байсан бизээ. Тэг тэгсээр нэгэн цагт арай гэж цаснаас цухуйсан мөнөөх шовх хаднуудын нэгнийх нь араар орлоо. Хавцлыг хэдийнээ сүүдэр ав чихсан үе билээ. Салхи намдаж, үдэш болов. Морь хүнгүй дагжин чичирнэ. Гал гаргаж үзэх санаатай, түлээ түүе гэтэл хөлдүү хомоолоос өөр нүдэнд харагдах зүйл гэж үгүй тэр нь ядахдаа цасанд тас шигдчихсэн тул авсаар автана гэж үгүй аж. Гурван хүнийг түлэх юманд явууллаа. Гэтэл энэ үед Баянак нууцан дороо ажиллаж гарах нь тэр. Мөс ховхолж, хад нүдэх дуулдана. Осгочихгүйг хичээж л ингэж байна даа гэж бид бодлоо. Түлээнд явуулсан нөгөө гурав маань

бүр харанхуй шөнө болсон хойно сая л буцаж ирлээ. Адуучны хошийн буурин дээрээс ганц гадас олжээ. Өнөөхий чинь цуулж гал гаргалаа. Хөлдүү хомоол гэсч, эврэх хүртэл хэдэн ч цаг өнгөрсөн юм дээ, нэг хүн хормой хотоороо үргэлж дэвж байхын учиртайг хэлэх үү. Бүгдээрээ л ээлжилж дэвлээ. Яасан ч хүйтэн, яасан ч урт байсан юм тэр шөнө. Морьдоо чөдөрлөх байтугай, сул ч зогсоохын аргагүй, байс байсхийгээд л нааш цааш хөтөлж, туусаар үүр цайлгав. Тэгээгүй бол зогсоогоор чулуу төмөр болчихоод нэг л мэдэхэд түсхийтэл унаад ирэх байсан биз. Тогоотой цас нэгэн цагт хайлж, дараа нь бас буцалсан юм байх, хөлдүү махыг хальс шиг нимгэн цавчиж чанав. Хээрийн галын дэргэд урамтай байдаг билээ. Тэр шөнө тиймгүй байлаа. Бүгд л чимээ чагнан, дор дороо бодол болчихсон, хааяа нэг дуугаравч хүчилсэн нь илт. Хавцал дотор тас харанхуй, хавцлын дээгүүр харин тэнгэрийн одноос оройн ца санд тусч ойсон туяа урд өдрөөс гээгдэж хоцорсон зурвас гэгээ адил бүгээрнэ. Гэтэл энэ нь сэтгэлийг бүр ч давчдуулна. Сар гарч өгөхгүй л байв.

Баянак ажилласаар л. Хумс нь элэгдэж, сар вууныхаа ясыг гартал чулуу шороо ухан, газрын гүн рүү амь зулбагч тарвага сэтгэлд бодогдоод бие зарайн, хуйх татваганана. Хоол арай гэж нэг юм буцлав бололтой. Тогоогоо гал дээрээс авсан ч үгүй, шөлөн дотроос улаан гараараа самардан ава хад халууныг өчүүхэн ч эс мэдэрнэ. Хэн нэг нь, “Мах идэх үү, Баянак?” гэж дуудлаа. Гайхалтай нь Баянак хад нүдэхээ больчихов. Түрүүчийн эр “Идмээр бол чи л наашаа жаахан дөхөхөөс биш, бид нарын дунд наана чинь хүртэл шидэх тийм чадалтан алга шүү” гэсэнд харанхуйн дундаас ийм хариу дуулддаг байна. “Өглөө явахдаа наанаа үлдээчихээрэй!”. Энэ үгэнд гуйсан өнгө илт байлаа. Гэтэл Доёбуу ингэж хашгирлаа. “Бид эндээс явахгүй! Нөхөр Баянак танд нар гартал бодох хугацаа олгоё!” Баянак, “Наад үгий чинь танд харин эргүүлж хэлмээр байна би, нөхөр эцэг! Ургах нарнаар та нарыг энэ хавцлаас тонилгоно гэдгээ андгайлъя!” Наргианаар хэлсэн үг ийнхүү дайсагналаар дууссанд сэтгэл гонсойх мэт бид дуугаа ху раан сууцгаав. Баянак харин бүр түрүү чийнхээсээ эрчтэй ажиллах шиг болох нь дэмий алдсан хэдэн хормоо нөхөж авах гэж бодсон мэт ээ. Мах, шөл бээрсэн биднийг бүлээцүүлж эс дөнгөв. Гэгээ ороход харвал Баянак хадны шовх үзүүрийг нэлд нь эмтэлсэн байв. Гарсан чулууг нумруулан өржээ. Хажууд нь бас асар том мөсөн овоо үзэгдэнэ. Юунд ингэсний нь учрыг бид ойлгосонгүй. Дотроо яахаа зөвлөлдөв. Нэг хэсгээ эндээ үлдээн, нөгөө хэсэг нь буцаж яваад сумын төвд очиж хэл өгөөд, дулаан хувцас, хоол унд, түлээ түлш, майхан юм уу хош авчирья гэсэн саналыг Доёбуу гаргав. Гэтэл хамгийн залуу маань үүнийг эсэргүүцэж, тэгж цаг алдахын оронд шууд л араас нь авирья, хэрэгцээ тохиолдвол хойно үлдэгсэд галаараа хамгаална биз гэлээ. Санал хуваагдаж, миний шийдийг хүлээж байв. Баянакийг эсэргүүцэхгүй гэж яг баттай эс итгэвч, төрүүлсэн эцгээ ч юм уу нутгийнхаа хэн нэгэн хүний амь насанд халтай юм хийчихнэ гэж даанч бодож эс чадан эргэлзэн зогсч байлаа.

Гэтэл Баянак, “За, болзсон нар маань ч цу хуйгаад ирлээ. Одоо би арав хүртэл тоолно шүү!” гэж хашгирснаа шууд л “нэг, хоёр...” гэж тоолж гарлаа. Түүнийг ингэлээ гэж айгаагүйгээр үл барам, “хөөрхий минь бүр тартагтаа тулахдаа сүрдүүлээд нэг үзэхээр эцсийн ядарсан аргаа хэрэглэв дээ” гэж өрөвдөн, харангадах гэж байгаагаас зайлахгүй даг гэж бодтол захиад байсан мах нь санаанд орж дээшээ харвал тэнгэр даан ч хүрэмгүй алсад цэлийн байлаа.

-“...долоо, найм, ес-арав!” Нум руулан өрсөн хад захаасаа ганхасхийх шиг болсноо суури наасаа салан дээрээс харваад ирэх нь тэр! Яах гээд байсных нь учрыг одоо сая л ойлгохдоо,

уур манасхийн шатаж, тэр мөртлөө ийнхүү байд гаараа ориллоо, “Хөөш чи галзуурав уу, Баянак?! Амьтан алах нь байна, болиоч!...” Өнөөх хад гэнэт нөмрөн ирсэн аюулын өмнө ухаан алдчихаад орлилдон, янцгаалдсаар аль л толгой хандсан зүгт зугтаж яваа хүн, адгуусын гол дунд лүгхийн буугаад цаашаа ойн одохдоо замдаа хичнээн ч юм олон чулууг ховх татан агаарт цацлах дараа дараагийн агшинд орой дээрх тэнгэр нурж, улан доорхи газар цөмөрч байна уу даа гэж санагдахаар нүргээн дуулдав. “Галлаад!” гэсэн миний тушаалаар энд тэндээс хэд хэд буудах сонсогдсон боловч ар араасаа шуугин ирэх хад, мөсний дороос амиа авч гарах нь аргагүй л хэн хүнд тулгарсан үүрэг тул төдөлгүй бүгдээрээ зугтаав. Би уурандаа уйлчихсан ха райлгаж явах даа олон дахин унаж, тэр тоолонгоор, одоо ч үхлээ дээ гэж бодож амжиж байлаа. Тогоон чи нээ чулуунд нэг морь цохиулж намсхийн унахад хавийн цас нь улсхийх шиг болохыг л лавтай хар лаа. Баянакт миний гомдож, уурласан гэж жигтэйхэн, хүслээр болдогсон бол тун даруйхан барьж аваад амин голы нь тасалмаар санагдана. Гэтэл яг тэрхэн үедээ бүр арчаагүйдээ тулчихаад зугтаж явлаа. Миний урд эрчүүл, тэдний урд алдууран давхисан морьд... Том, бага чулуу, мөс араас дараа дараагаар гүйцэн ирэх тул уул хавцал тэр чигээрээ нуран урсаад ирж байх шиг. Хавцлын аманд хүрч хажуу тийшээ гараад сая л зогсов. Хөгшин залуугүй бүгд унан тусан ханиалгаж, зарим нь бөөлжицгөөнө. Дуугарах тэнхэл байсангүй.

Эцэст нэг нь, “Ингэж хөглөх ч гэж дээ” гэж зовонгуй дуугарлаа. Хүн бүр л амьд мэнд үлд сэндээ гайхан баярлаж, ганц морь гарзадсаныг юман чинээ санахгүй байгаа бололтой байв. Харин миний уур шар улам улам зангиран буцалж, “Мориндоо!” гэж зарлан тушаалаа. “Мордоод хаачих гэж?” хэмээн гайхзанасан дуу гарсанд би газар дэвслэн, “Хаачмаар байна? Харьж авгайтайгаа нялуурмаар байгаа биз, тийм үү?” гэж хашгирлаа. Ахин дуугарах хүн гарсангүй. Явгарсан Борва гэдэг бяцхан чөргөр, цагтаа зартай анчин явсан өвгөн нэгэнтэй нь сундлав.

Ахиад л хавцлын жимээр ороод хэсэг явж байтал Доёбуу, “Миний хэлснээр болбол яасан юм бэ, даргаа? Хоол, хувцсаа базааж аваад энэ л хавцлын аманд отоод суугаад байхад өлөн нүцгэн Баянак гараа өргөсөөр өөрөө л хүрээд ирэх нь зүй биш үү?” гэв. Бусдуул нь дуугарахгүй байхыг бодоход түүнтэй санал нийлж байх бололтой. “Би л араас нь авирья. Ахиад хад нураах бий гэж айж байгаа хүмүүс байвал мориноосоо буулгүй зугтахад бэлэн байж байхгүй юу даа” гэж би хорон үгээр хариуллаа.

Таг дуугүй явцгаалаа. Доёбуу хэ дийгээр гэдэс гүзээ өвдлөө гэж юм хэлээгүй боловч, хамгийн сүүлд явж байв. Алагдсан морины дэр гэдүүр өнгөрөхөд ч дуурах хүн гарсангүй. Цасан дээгүүр урссан цус хөлдчихсэн байв. Баянак нөөцтэй үлдсэн бол яахав? гэсэн бодол төрөн, түүнд хариу олоогүй явтал нууц нь харагдаад ирэв. Өнөөх өрсөн чулуу, овоолсон мөснөөс юу ч үлдсэнгүй, харагдахаас цасан дотор гар сан том ангархай хар нүх л байв. “Ай, юу ч үлдээгүй байна!” гэж хэн нэг нь баярлан хэлэв. Ингэж хэлээд дөнгөж дуустал тавхан алхмын цаана Баянак гар буу барьсан зогсч байхыг олж харлаа. Давхийн зогтусав. “Чи, бид хоёр ингээд өнгөрдөг байжээ, хүү минь!” гэж бодлоо. Уур шар гэнэт алга болсон байлаа. Юм бүхэн нь зэрлэг, эршүүд байдлыг илтгэнэ. Царай нь цонхийж, нүүрнийх нь хэв маяг улам ч тодроод, гялалзсан өтгөн хар үс өргөн мөрий нь бүрхэн унжина. Гутлы нь харвал улаараа ангайн салсны нь сураар хүлж торгоосон, дээлий нь харвал хир толбон дээр далан долоон нөхөөс болсон, бүсэнд нь ганц бор ятуу хавчуулаастай байна. “Эмээл дээрээ хөдлөлгүй

чагнаж байцгаа!” гэснээ гар буугаа бидний өөдөөс чиглүүлж “Би одоо гурав хүртэл тоолно. Тэр хооронд нь та нар зүүн гараа жолооноос салгалгүй байж буугаа хаяарай. Арга мэх хэрэглэх гэвэл харин дэмий шүү. За, нээг!” гэх нь тэр. Нөхдийг харвал эмээл дээрээ хөшчихсөн юм шиг харагдана. “Хоо-ёр!” Доёбуу түрүүлж, бусад нь дагаад буугаа мөрнөөсөө мулталж газар хаяв. Би ч хоцорсонгүй. “За одоо сумтай дайзаа аль!” гэв. Хүссэнийг нь дор нь биелүүлэв. Буутай гараа доош буулгаж, “За одоо жаахан ухраад зогсчих” гэснээ хүрч ирээд буу дайзыг цуглуулж нэг дор овоолж хаяхдаа хамаг сумы нь хаман авч хоёр дайзанд дүүртэл чихээд урд, ардаа зөрүүлэн бүслэв. Тэгснээ овоолоостой буунаас нэгийг гох төмөр дээрээс нь шүүрч авангаа алсаас далайн өмнөх хад руугаа буулгахад бууны хуй зомгол болон хэдэн хэсэг бут үсрэв. “Энэ бол галзуурсных биш, өлссөнийх. Хэлэн дээрээ юм тавилгүй гурав хонов. Та нар намайг гөрөөс үзсэн чононоос дор мөрдсөн шүү. Шөнөжин мах чанаж, бас мах идэх үү гэж асуусан болохлоор та нарыг би үмх мах үлдээчихсэн байх болов уу гэж горьдсоныг минь яана. Ямар сайндаа л нударгын чинээ энэ шувуу руу баавгай руу шагайхдаа лавлаагүйгээрээ лавлаж шагайхав дээ. Тэгээд газарт унахаас нь өмнө шүүрч аваад балга хүрэхгүй халуун цусы нь сорчихоод дотор онгойх шиг болсон шүү. Та нарыг хүрч ирээгүй бол түүхий чигээр нь ч идэх байсан байх!” Ингэж хэлээд бугарсан зомголыг түүж, хороолон тавиад, сум ны тол гойг шүдээрээ булга татан, дор нь дарий нь асгаад шүдэнз зураад шидтэл дүрсхийн асав. Тэгээд өдий нь эгшний дотор зулгааж хаяад ятуугаа шарж эхлэв. Баянак энэ үед бидэн рүү ер харахгүй, гагцхүү ажилдаа улайран суух бөгөөд хэрэв хэн нэг нь түүнд сэмхэн ойртон очсон бол анзаарахгүй байсан нь илэрхий. Даанч тэгэх хүн гарсангүй, түрүүчийн айдас өнгөрөөд, хожим хуулиас айх нь сэтгэлд хараахан сэрээгүй, одоохондоо гайхалд автчихсан бүлгийтэл ширтээд л байцгааж байсан хэрэг.

Ятууг хуйхлах, идэх ч гэж дээ, ёстой хормын л хэрэг боллоо. Дүрэлзсэн дөлөн дотор улаан гараараа хэдэнтээ урвуулан барих шиг болсноо агийсан хэрсэн шиг өчүүхэн хар юмыг хоёр алган дээрээ сэлгэн бөмбөрүүлснээ тас тас татаад амандаа хийн, зажилсан эссэн нь мэдэгдээгүй байтал ясы нь тургичихав. Ийнхүү хооллосон шүү болчихоод, сая л бидэн рүү харж хэлсэн нь, “Амь насыг тань аюулд учруулав. Алив нэгэн буруу санаанаас биш, амьд явахын хүслэнгээс ингэв. Ядрахдаа хулгай ч хийж үзэв, хүн ч алах шахав. Тийм ээ, осгоод үхчих гүйн тулд энэ хуучин хөдсөн дээлийг хулгайлсан юм. Хожим эзэн нь бол сон хөөрхий хөгшний босгоор хоёр үнэгний арьс давуулж хаясан ч өөрийгөө түүний өмнө өртөнд тооцсоор л явна. Учир нь хэрийн хүний тоож мөрөндөө углахааргүй энэ дээл бол ядарсан надад юугаар ч сольшгүй эрдэнэ юм. Тэгэвч өрөө нимгэлэхээр өнөө айлдаа ахиж очихын цагт эргээд л нэг юмы нь хулгайлж хэвтэж ч магадгүй. Хүн ийм л болдог юм байна. Юунд бусдын араар сундлахад хүрэв, буурал ах Борва минь! Эмээлт морий чинь хулжаав уу, бэртээв үү, эсвэл бүр алав уу би? Хэнийх нь бууг бас сүйтгэв, тэр хүнээс өршөөл гуйя. Үмх халуун махны үнэ цэнийг та нар даанч төсөөлж мэдэхгүй. Дээр нь одоо бас нэг бууг хамаг сумтай нь авах боллоо. Амьд явах л гэснийх. Аав минь, ах дүү нар минь бүгдээрээ уучлаарай. Амьдрах хоногийнхоо тоогоор өртөн чинь явъя. Хүчээ нэмэрлэхийн оронд үймээн тарин төвөг учруулж байгааг минь нутаг усныхан минь уучлаасай. Хулжиж нуугдавч хатуу хүтүүгий нь нугалалцаж явааг минь мэдээсэй. Явсан замынхаа чулуугий нь боловч түүж, хоносон агуйныхаа хогий нь боловч цэвэрлэж, хашаа хороо нь нураа бол сэлбэж, худаг ус ширгээ бол ухааж, сүрэг малы нь алсаас хариулж, хүн зоны нь холоос хайрлаж явдаг минь үнэн билээ!”.

Ингэж хэлээд уйлчихлаа, хөөрхий минь. Би ч бас уйлж, тэгэхдээ ямар ч гэсэн амьд явахыг

хүссэн энэ сайхан залуу бол миний хүү юм шүү дээ гэж бахдан бодож, дотроо түүнд урт наслахыг ерөөж байв. Сайхан ч өглөө байлаа. Хадган цэнхэр тэнгэрт ассан нарны бүлээн амьсгалыг бие өвлийн жавар дундаас цацраг цацрагаар мэд рэх шиг болох нь хавар заавал болохын баталгаа мэт ээ. Баянак овоолоостой буун дотроос харж харж нэгийг авч үүрээд хэлсэн нь, “Одоо намайг сум л гүйцнэ. Тэгэхдээ тэр сум чухам энэ л буунуудын нэгнээс гарч магадгүй. Гэхдээ та нар тэднийгээ ав л даа!”. Тэгээд буунуудыг хоосон дайзтай цуг авчирч, бүр гар гарт маань бариулж өглөө. Хэмхэлсэн буу Доёбууд таа рав. Таяг болсон нүцгэн төмрийг тонгойж авахдаа гар нь салгалж байсан санагдана. “Сүр сар” хочтой Дакагийн буу дугав. Хожим ч авсан л даа.

Биднийг далд орон ортол Баянак хөшөө мэт зогссоор байлаа. Аа, тийм, яг далд орохын үед “Уучлаарай, аав минь, ах дүү нар минь. Надад буцах зам алга!” гэж хашгирсан шүү. Дуу нь тасалдан, үгээ арай гэж хэлж байх шиг санагдсан. Тэгэхэд нь Борва гуай “Хөөрхий хүү өнгөрсөн шүү” гэж шүүрс алдахад Доёбуу “Бид ч гэсэн өнгөрсөөн” гэж гаслан хэлж байлаа. Өөр юу ярилцсаныг санахгүй байна. Сумын төвд шөнө дундаас хойш ирэв. Өглөө нь эмнэлэгт хэвтлээ. Уушгины хатгалгаа туссан юм байх. Тав зургаа хоног ухаангүй дэмийрчээ. Сүүлд дуулахад, өдөр шөнөгүй Баянакийг дуудаж, тэгэхдээ бүр төрсөн ганц үр минь гэж байсан гэнэ. Хатгалгаа ч яахав яваандаа намдав, гэтэл хажуугаар нь бас зүрх болохоо байжээ. Эмчийн хэлэх нь юу ч бодохгүй байхыг хичээ гэнэ. Уг нь бодол санааг хорих эм гээчийг гаргавал зүгээр л юмсан.

Дуусашгүй жигтэй өвөл боллоо. Тэр цагийн эмнэлэг гэгч нь найман ор багтдаг ганц өрөө. Ажилчид нь гэвэл бага эмч, сувилагч хоёулхнаа. Хүмүүс ч гэсэн эмнэлгийг нэг их хайхардаггүй байж. Бүр үхлүүт өвчтэй хүн л хэвтдэг байсан юм чинь дээ. Тэдний чинь хаашаа харах нь цөөхөн хоногт л шийдэгдэнэ. Над шиг л үхэж ч, сэхэж ч болдоггүй амьтан байсангүй. Нэг жаал хүү л их удсан. Сүүлдээ ч дийлдээгүй юм. Нэг насаараа цуг байснаас өөрцгүй дасчих юм билээ. Бие нь ер засрал авалгүй улам муудсаар цас бударсан нэгэн өглөөгүүр өнгөрч билээ, халаг минь. Урьд шөнө нь уг нь сайхан унтаж хоносныг нь яана. Сэрэнгүүт цонхоор цас орж байгааг харчихаад гунихарч дуугүй болсон юм. Дахиад унтчихлаа л гэж бодлоо. Гэтэл тэгэхэд л өнгөрчихсөнийг нь үдийн үед мэдэцгээв. Өвчтөнгүүд эцэг эх, ах дүү, гэр орон, мал харынхаа тухай сураглан сураглан хойноо санаа зовж, эдгэрч гарах үе нь дөхөөд ирэхэд нойр алдан хөлсч хөөрнө. Ганцхан би л сураглах ч юмгүй, баярлах ч юмгүй хэвтэнэ. Хамгийн хэцүү нь сэтгэлийнхээ зов лонг хүнтэй хуваалцах арга алга. Тэр ч бай тугай, өвчтөнгүүдэд надаас нууж ярилцдаг зүйл байсныг нэгэн удаа гадаа явж байгаад орж ирэхдээ мэдэж авав. Түүнээс хойш шинэ соргог мэдээ дуулахсан гэхдээ унтсан хүн болж хэдэн цагаар хөндий хурхиран хэвтдэг боллоо.

Биднийг хөглөн буцаж ирсний нө гөөдөр нь аймгийн аюулаас хам гаалах хэлтсийн төлөө лөгчөөр удирдуулсан шинэ улс гараад хил хязгаар хүртэлх хамаг л уул хадыг арван хэд хоног самнаад ямар ч ул мөр ололгүй буужээ.

Сумын удирдлагаас намайг хааяа эргэж ирдэг байв. Хүмүүс надтай урьдынх шигээ, нөхөр намын үүрийн дарга юм уу, аль эсвэл нөхөр дарга гэхийн оронд Жанибек гуай гэж ярьдаг болсныг анзаарлаа. Үүнд би гомдсон ч үгүй, зүгээр л бяцхан гайхаж байв. Сумын дарга ч эргэж ирээд намайг хүлээсэн ажил ч бишгүй л байгаа юм ярив.

Дөрөвдүгээр сарын 12-ны өдөр эм нэлгээс гарав. Эмч уг нь гурав хоногийн чөлөө өгсөн юм. Гэтэл муу оромжиндоо арай гэж ганц хо нож аваад маргааш нь ажилдаа орлоо. Үдээс хойш аймгийн төлөөлөгч оролцсон хурал болж, миний тухай авч хэлэлцэв. Бас Баянакт зэр зэвсгээ алдсан явдлыг миний санаатайгаар зохион байгуулсан ажил гэж Доёбуу мэдүүлэг өгчээ. Би юу ч үлдээлгүй бүгдийг ярилаа. Баяна кийн шөнө дөл гэрт минь ирснийг хүртэл нуусангүй. Харин Доёбуугийн гүтгэлгийг ня цаав. Хурлын ид дундуур Зэвхий Гасын нүд нь орой дээрээ гарчихсан давхин орж ирээд “Цаана чинь Баянак! Хара Хоовд Довай эмгэнийд хонож байна!” гэлээ. Хурал завсарлах нь тэр. Сумын дарга намайг сүрхий анхааралтай харснаа, “Нөхөр Жанибек! Танай хүн намыг нэг удаа хуурсан байна. Нөгөө, нөхдөө санаатайгаар аюулд оруулсан гэдэг үгийн үнэн худлыг хожим шалгаж олох болно. Харин одоо бид танд эндэгдлээ засах боломж өгч байна. Ахиад л таны удирдлагаар явуулна. Ингэх нь хэн хэндээ ашигтай юм. Яагаад гэвэл Баянакийг амьд барих хэрэгтэй байна. Үүнийг та л чадна. Тэгэхдээ өөрийнхөө болон нөхдийнхөө аюулгүй байдлыг дээд зэргээр хангасан байвал зохино” гэлээ.

Зэр зэвсэгтэн дорхиноо цугларав. Урьдын хүмүүсээс Борва хөгшин л алга. Аймгийн төлөө лөгч, сумын дарга хоёр цуг явахаар болов. Хара Хоовд үүрийн харанхуйгаар хүрэв. Эрч нь харьсан жавар дундаас нялх ногоо, халуун бууцны үнэр хамар дэлсэнэ. Үзүүрийн цаана морио орхиж, явгалан явсаар хотын бараа хараг дах газар хүрч ирэв. Гэр хотгүй унтаж байв. Нохой үгүй бололтой, хашааны зүүн өнцөгт том хар мануухай навсайд зогсоно. Хүн болгонд байры нь зааж өгөв. Бурай зуухан доторх овгор шорооны, Доёбуу мануухайн, Пагвы, Дака хоёр тэр баруун хадны ард нуугдав. Аймгийн төлөө лөгч, сумын дарга хоёртой би энэ урд хадны ангалд орж суулаа.

Гэр хөлийн дор, хүн байтугай хулгана ч хаал гаар нь бултасхийвэл алдахын аргагүй ойрхон байв. Сумтай буу өвөр дээрээ тавьчихсан дуу гүй сууцгаалаа. Юу болох гэж байгааг даанч төсөөлсөн шинжгүй, дөлгөөн гэрэлтэгч сүүлчийн одод, амгалан нойрсогч гэрийг харан харан хувь заяандаа гомдон суув. Довай эмгэнийг бол зүгээр л нэг таньдаг байлаа. Арав гаруй жилийн өмнө бэлбэсэрсэн. Тэр цагаас хойш ганц охин Гумайтайгаа айл амьтнаас зайдуу ганц гэрээрээ явсаар байгаад зожиг нэр авсан хүн. Охин нь царай зүс, нуруу туруугаар бол хэнийг ч урдаа оруулахааргүй мөртөө ааш зан гэж Довай л гэсэн үг. Олон ч харцуул тэднийхээр эргэлдэж, эх охин хоёрт зэрэг хөөгдөн их ч хөгтэй юм болдог байсан. Оргодлыг бол харин гэртээ оруулж дээ гэж бодоход амьдрал гэж даанч ээдрээтэй. Гэгээ орж, хонь ямаа майлалдан, болжмор жиргэж дэлхий сэрэв. Гэрийн эсгий үүдийг сэвхийтэл хаян үүрийн шар туяан дор Гумай гарч ирлээ. Бие засахаар явах замдаа байн байн зогсч зүг зүгрүү харуулдахдаа өнгөрөгч шөнийн сүүлчийн бүрэн хий орогносоор байсан хадны ан галд шигдэн суусан биднийг олж харсангүй. Буцаж ирж, өрхөө татаад оров. Гэрт гэрэл асч, өрхөөр утаа гарч, тогоо шанага харших дуулав. Тэгтэл эсгий үүд ахин сэвхийтэл өгөгдөн Баянак гарч ирлээ. Хөндий өгсөн ирэх зам руу саравчлан харна. Дэргэдэх нөхөд минь давхийн хөдөлж намайг харцгаав. Баянакийг эргэж харахаас өмнө амжиж хөдлөх хэрэгтэй байлаа. Буугаа сугавчилсаар аяархан доош буув. Хоорондын зай маань арваад алхмаас хэтрэхээргүй харагдана. Эсэр гүүцэлгүйгээр буулгаж авна гэ дэгт итгэснээс нэг их цочоохгүйг хичээн “Бүсэлчихээд байна. Бууж өг дөө, Баянак!” гэж огцом ч гэсэн дэндүү чанга биш хэллээ. Өнөөх чинь бүр цочихгүйн муухайгаар цочив бололтой, үнэгэн малгайгаа толгойноосоо мулт шидэгдтэл огцом эргэв. Тэгээд яасан гэж санана, гайх лыг чинь! Өврөө уудалдаг байгаа. Би өөдөөс нь буу чиглүүлж, “Гараа өргө! Буудлаа шүү!” гэж хашгирлаа. Гэтэл юун гараа өргөх,

юун бууж өгөх! Үзэлцэхийн хүслэн болсон омогтой залуу азарга шиг намир сан хар үсээ арагшаа шидэн, гар буугаа суга татан гаргаж ирээд юу юугүй өөдөөс шагайх нь тэр шүү, шаар чинь! Надад хүлээх эрх байсангүй, эгшин бүрт хүний амь сүйдэж мэдэх болов. Яая гэхэв - дарж орхилоо”.

Ингэнэ гэдгийг мэдэж байсан хэр нээ би агзасхийн цочжээ. Жанибек бахардан сууна. Дүлий цагаан тэн гэрээс том ширхэгтэй цас нүүр нүдгүй асгарна. Гал асч дуусаад гагцхүү нурамны захад дутуу шатан үлдсэн ганц хоёр аргалаас үзэгдэхийн төдий утаа савсана. Зовлонтой нам гүм байлаа. Гэтэл босч очоод аргал авчирч галыг сэргээчих зориг надад байсангүй. Унтарсан нурмыг өтөл нөхөр минь хув хуурай нүдээр гөлрөн сууна.

“Ургаа мод унагааж үзсэн үү? Яаж гэнэт тэнцвэр алдан, яаж очоод, яаж унахыг нь, яаж дуугарахыг нь, ой хэрхэн нүргэлж, араас нь ямаршуу нам гүм болдгийг нь анзаарч харсан уу? Буун дуу хол ойрын хаданд цуурайтах нь том жижиг олон буугаар хэд дараалан буудах шиг дуулдав. Баянак эгээ л мөчир шилмүүс нь гүйцсэн лут өндөр хар мод шиг унасан юм. Алтайн хүрэн улаан буга шиг цусан дотроо хэвтэж байв. Гэрээс гүйн гарч ирсэн Гумай часхийтэл дуу алдсанаа дороо ухаан алдан ойчжээ. Араас нь гарч ирсэн эмгэн охинтойгоо зууралдах зуур хараал урсгана. Нуувчнаасаа гүйлдсээр хүрч ирсэн эрчүүд Баянакийг тойрон амьсгаадсаар зогсоцгооно.

Газар тэс хөлдүү байв. Ухах багаж маань гэвэл ганц муу хүрз, зөндөө удаан ноцолдож байж бяцхан хонхор гаргахшуу болов. Суган доогуур нь тэврээд өргөтөл цусны үнэр авч дотор муухайрахад толгойгий нь цээжиндээ наагаад нүдээ анив. Дээл гутлыг нь тайлсан ч үгүй, үнэгэн малгайгаар нь нүүрий нь бүтээв. Шороо дутахад уулын хайрга хормойлон авчирч байсан санагдана. Тэгээд яасныг мэдэхгүй юм.

Эмнэлэгт ухаан орлоо. Тэмээгээр ачиж ирсэн гэнэ. Эх охин хоёрыг гэр малтай нь нүүлгэж Ховд тал руу авчирч л дээ. Үхэх нь л гэж бодож байлаа. Гэтэл ахиад л амьд үлдэж, арван гурав дахь хоног дээрээ эмнэлгээс гарч ирлээ. Шууд ажил дээрээ очлоо. Завсарласан хурал үргэлжилж дорхноо дуусав. Хэрэг санасанчлан сайнаар дуусч өгөөгүйд харамслаа илэрхийлцгээнэ. Энэ удаад би үүргээ биелүүлжээ. Намайг хоршооны дарга болгохоор шийдээд байж. Би үгүй гэв. Энэ бол намын үүрийн даргаас огцрууллаа гэж гомдсоных биш. Өнгөрсөн сарууд намайг өөрчилжээ.

Баянакийн үхэл бол миний хувьд оюун, бие, түүний эд эс болгоныг доргиосон цохилт байлаа. Хоршооны дарга хий гэхэд нь “За” гэсэн бол би өдий хүртэл төрийн албанд зүтгэсэн болоод л явж байх байсан ч болов уу. Гэтэл яагаад заавал би хоршооны дарга болох гэж? Надаас залуу, надаас мэдлэгтэй хүмүүс бишгүй л байна шүү дээ, тэд хийг гэж бодсон хэрэг. Одоо бодоход зөв л шийджээ. Хараад явахад бараг л хүн бүрт ийм нэг гэм байна уу даа. Хэн боловч хорвоогийн жамаар өтөлж, хичнээн ч жил бай хийчихсэн ажилдаа яваандаа тэнцэхээ байх юм л даа. Гэтэл өөрөө үүнийгээ мэддэггүй юм уу, аль эсвэл мэдлээ ч гэсэн мэдээгүй юм шиг л явахыг боддог юм уу, би эндээс чинь больёо гэх нь үгүй, юу ч л атугай эрдэм чадлаар өөрөөсөө илүү залгамж үеийнхнийхээ замд саад болоод байх, тэг тэгсээр нэг өдөр бүр болохоо байхад хүрэх юм. Ямар ч ажлыг өөрөөс нь илүү хийчих хүн байх л юм бол түүнд зам тавьж өгөөд өөрөө тэнцэх ажлаа л олж хийнэ биз.

Тэр жил хаврын шувтаргаар айхтар зудархуу болов. Таван сарын дундуур гэнэт их цас орж араас нь хэд хоног цасан шуурга нүдэв. Зургаан сар дундаа орчихоод байхад л Сарыг Сигенд хүүш газраар цастай байсныг бод л доо. Бас малын өвчин гарч гарзтай дуулдаж байв. Үүл, газар, хүмүүсийн царай нэг л биш, харсаар байтал сэтгэлд шаналгаа төрүүлнэ. Заримдаа ингээд л энэ чигээрээ зун ирэхээ больчих юм биш биз гэж санагдана.

Би гэдэг хүн өнөө л бахь байдгаараа, даржин зүдүү хэвээр, ядахдаа уналгын ганц морь ч олж аваагүй явжээ. Өнөө байгаа хэдэн морь, эмээл хазаар, буу, гэр-надад өмч гэхээр юу байна, тэр бүгдийг хожмын ажлынхаа хөлсөөр л олж авсан хэрэг. Тэмээчин болов оо. Үүний учир нь дөнгөж байгуулагдсан нэгдлийн таван тэмээг гардаж аваад хариулчих амьтан олдохгүй байж л дээ. За тэгээд тэмээ маллах нь ямар байв гэвэл дарга хийхээс л хэцүү санагдаж байсан үе бий.

Таван сарын 23-нд тэмээгээ Са рыг Хөлөөс Боргасун руу туув. Нэгд лээс морь, майхан авсан юм. Ала Буд өнгөрөөд явж байтал Доёбуу оролц сон хэдэн хүнтэй тааралдав. Гумай гэрээсээ алга болоод дөрөв хонож байгаа, түүнийг эрж яваа гэнэ. Яагаад ч юм би Хара Хоовоор дайраад өнгөрөө гэж бодлоо. Уг нь ч зам тойруу л даа. Цастай эл хуль оргиж байв. Тарваганаас өөр нүдэнд торох амьд амьтан гэж үгүй байтал нөгөө үйлтэй шөнө бидний морио орхиод цаашаа явсан үзүүрийн тэнд ойртож явтал хүн, хүндээ аюулын цээл хоолойтой эмэгтэй хүн дуулаад байх шиг болов оо. Тэгтэл дууны үг нь хүртэл ялгараад ирэхийг сонсвол,

“Халил хад минь ангайгаад өгөөч

Хайрт ганцыгаа хадгалъя өвөрт чинь”

гээд байх юм. Тэр сүсэг бишрэл гэд гийг чинь би мэддэггүй явсан юм. Одоо ч гэсэн мэдэхгүй. Тэгэвч нэг л бие зарайгаад явчихлаа. Өвөлжөөний захад тэмээгээ орхичихоод, цасанд даруулсан хотын хаалгаар ороод иртэл бүр чихний хажууханд:

“Харийн газар зорьсондоо ч хүрлээ

Хайрт ганцдаа очих минь л үлдлээ”

гэж дуулав. Тэгтэл Бугту-Гириш, Буга - Жарын тайгаа хадны ангалд байх шиг санагдахад лавлан харвал энгэр задгай, нөмгөн дээлтэй, үс нь сагсайсан Гумай сууж байх. Урд нь хэвтээ урт бор юм бол үхсэн Баянак болохоос эс зайлна! Би дуу алдаад эргэж давхих шахжээ. Үргэсэн тэмээ хоорондоо шахцалдан, чихээ сэрийлгэн зогсоно. Бууж, морио хаднаас уяд хөөрхий амьтны өөдөөс явлаа. Үнэгэн малгайг хуйлж өвөр дээрээ тавьчихсан, бүүвэйлэн дуулж алдаж байна.

“Өнөө чи эрхийн чинээ байвч бүүвэй, бүүвэй

Өглөө босоход хаан болчихсон байна даа, бүү вэй, бүүвэй”

Урд нь хүрээд очсон чинь өөдөөс инээмсэглэн, гар сунгаж:

“Хан Алтайн эзэн цагаан өвгөн иржээ

Хайрт эцэг чинь одоохон ингээд сэхнэ, үр минь”

гэж дуулснаа гэнэт дуугаа хураан ца райгаа ба райлгав. Нүүр рүү минь сүрхий хүйтнээр харж сууснаа гэнэт хуйлсан малгайн дотроос гонзгой хөх чулуу гаргаж ирээд “Алуурчин!” гэж ясанд нэвчим зэвүүн чанга орилонгоо өөдөөс минь гялсхийн үсрээд ирэх нь тэр! Нүднээс минь гал цахилах шиг болсноо толгой дүйрээд явчихлаа. Бариад авлаа. Гэтэл тэнцвэр алдаж дор хунгарласан цасан дотор очиж уналаа. Өнөөхий чинь тавьсангүй, дээрээс нь дарж ойчжээ. Бүсээ тайлж хоёр гары нь ард нь зөрүүлэн хүллээ. Их ноцолдсон доо, хазуулсан ч, маажуулсан ч. Тэр хооронд нүд, амруу урсч байгаа цус ч гэж тоймоо алдав бололтой, хүлж аваад сая л шархаа боов.

Дүүрээд явъя гэсэн чинь хүч хүрэх юм биш, ядахдаа өшиглөж нулимахы нь яана, орилж, харааж зүхэж байгаагий нь ч бүр юүхэв. Арга тасрахдаа цулбуураараа хоёр суган доогуур нь оруулан оосорлож, өөрөө мордож аваад хөөр хий солирсон амьтныг дөрөөвчлөөд явж үзсэн чинь болж байв. Морь номхных л доо. Зай луул, хэсэг айхтар цааргалснаа номхорч, учиргүй уйлж гарав. Тамир тэнхээ нь барагдаж байгаа бололтой, сүүлдээ хөл нь үзтэл бүр гишгэгдэхээ болив. Тэгэхээр нь эмээл дээр өргөж гаргаад дүүрч авлаа. Үе үе л бяцхан хөдлөхөөс биш ихэвчлэн тэрүүхэндээ цурхиран уйлах төдий томоотой явж байлаа. Нэг л удаа бугуйн дээрээсээ хазуулж цочихдоо түлхээд бүр унагаад орхисноос хойш бүсний үзүүрээр амы нь даруулан боож авлаа. Ахин тийм явдал гарсангүй. Шөнө дундын үед голын наад эрэг дээр байсан айлд хүрч хүн амьтан сэрээж, цус нөжөө угаалган шарх сорвио боолголоо. Ядарсан амьтны хүлээсийг султгаж цай уулгалаа. Өглөө эртлэн би Хара Хоов руу буцав. Гумайг салаар гол гаргаж эмнэлэгт хүргүүлэхээр тэнд үлдээв.

Тэр өдөр салхитай, урьд урьдын хаасаа хүй тэн, зэврүүн байлаа. Тэмээ хот бараадан хоножээ. Газар гэсэхийн оронд дээрээсээ улам ч нягтран хөлд сөн мэт. Чулуугаар нүдсээр байтал гарын арьсанд эрүүл газар ч үлдсэнгүй. Баянак чулуу болчихсон мэт хүнд байв. Хөөрхий бүсгүй яаж дааж тэр дээр гаргасныг бодоод бодоод олсонгүй. Газрын үнэр шингэж, өнгө зүс нь ч эгээ л хад чулуу шиг болсон байв. Хөлдүү нүхэнд нь оршуулж, хөлдүү шороо чулуугаар даруулж орхиод явлаа даа.

Хавар, зуныг Боргасунд өнгөрүүл лээ. Наад маас хойш хоногийн өмнө сая л анх удаагаа сум орноор орлоо. Хүнс дуусаад тэр л дээ. Шарх минь эдгэрч сорви үлдсэн байлаа. Царай ч гэж бусдын айдас хүргэм юм байсан байхаас зайлахгүй, учир нь хүн амьтан нэг л өөдөөс минь эгцлэн харж чадалгүй, тэр ч байтугай замаас минь зайлж давхиад байсан шиг санагдана. Наадам үзье ч гэсэнгүй буцаж ирлээ. Муу майхнаа, хэдэн тэмээгээ хараад дотор бяцхан онгойх шиг болсон шүү.

Тэгэхэд эхийн хэвлийд явсан чи одоо орон гүрэн хэссэн том эр болчихоод явааг бодоход цаг хугацаа гэж хөөрхий талийгаад өгчээ. Хорин тавтай гэдэг чинь хүүтэй минь чацуу юм байна шүү. Гумай яасан бэ? гэж бодож суугаа биз дээ. Дөчин долоон оны хавар эмнэлгээс гэв гэнэт алга болсон гэдэг. Ахиад л их эрэл болсон, даанч хүний урамд ул мөр гаралгүй өнгөрсөн юм байх. Эх нь тэрнээс өмнө өөд болсон, айл амьтантай ч байсан, бүх юм ёсоороо болж өнгөрсөөн. Хожим бас нэг ийм юм болсон. Нэг найран дээр сууж байтал, чи мэднэ дээ, Шимэйэк гэдэг залуу лонхоор магнай руу минь дэлсчих нь тэр. Яаж байгаа нь тэр вэ? гэвэл

“Баянак Гумай хоёрыг төлөөлсөн хоёр сорви байг л даа” гэдэг юм байна. Хүмүүс намайг гомдол нэх гэсэн боловч би чимээгүй өнгөрсөн юм. Гэхдээ энэ бол миний л хувьд ноцтой хэрэг байсан юм шүү. Тэгээд ч чамд ярьж суугаа минь энэ.

За даа, чамд би Баянакийн түүхийг ярьж өгөх гэснээ бүр өөрийнхөө амьдралын түүхийг ярьчихлаа. Нэгэнт ингэсэн болохлоор тэмээ нийхээ тухай бас нэг хэдэн үг нэмээд хэлчихэе. Анх хүлээгээд авч байхад гуч хүрэхгүй байсан бол одоо зургаан зуу гарчихаад байна. Тал, хөндийг бүрхэн бэлчих хүрэн улаан сүргээ хара хад сэтгэл уужирч, магнай тэнийх шиг болно гээч. Нэгдлээ мянган тэмээтэй болгохсон гэдэг нэгэн үзүүрт бодол зүрхэндээ тээж явдаг юм даа. Гэхдээ энэ бол амьд явах хүслий минь ганцхан учир нь биш ээ. Юу болохыг харах хүсэл гэж байна. Юу юуны өмнө энэ л өсч өндийсөн, өтөлж өвгөрсөн, үүрд орших нутаг минь яаж хувирахыг харахын хүслэн байна.

Жанибек гуай хэлье гэснээ шавхан хэлж амрав бололтой. Босоод аргал түүхээр одов. Цас орсоор, нам гүм. Морьд унтаж байв.

Гал түлж, үлдсэн аргалыг агуйн мухарт шо войтол овоолж орхив. Хэн ч, ямар ч цагаар ирсэн аваад түлэхэд бэлэн байг. Тэгээд морьдоо сэрээж мордов. Хэсэг явж байснаа өтөл нөхөр минь зогсч: “Энд!” гээд доошоо заахад Баянакийн булшийг хэлж байна гэж ойлголоо. Гэрийн бууринаас баруун урд зүгт хоёр аргамжийн зай тай газар байв. Газрын шарх тэгтэл ул мөргүй эдгэрсэн юм уу, би л булш байхаар юу ч олж харсангүй. Тэгээд эргэж хөндийг уруудав. Хоц рон үлдэх нутаг эл хуль, доод газар нь дээд тэнгэртэйгээ өнчрөн эзгүйрсэн мэт атал гагцхүү асаагаад мордсон галаас минь дэгдэх цэнхэр утаа амьдралын бүлээн амьсгал тасраагүйг, тасардаггүйг илтгэх мэт ээ.

Цас нар жаргахын үед сая л зогсов. Дестигийн хярыг давтал бүр шөнө болов. Салхи үе үе сэвсхийн босч байсаар жигтэйхэн хүйтрэв.

Өглөө нь нэг овоо тааралдлаа. Ан чин хүмүүс хоногтоо хүрэхээр зорьж морддог, өнөө Баянак Овоо гэдэг нь мөн байлаа. Үүсгэсэн эзнийх нь нэрээр нэршсэн юм гэнэ. Баянак шүтлэгтэй байсан юм гэж үү?! Амьдрахын хүслэн гэж даанч айхтар хүчтэй байх юм даа. Анчид, мал хар эрсэн, оторлуулсан малчид, явдал аяны хэн боловч дэр гэдүүр нь өнгөрөх тоолонгоор нэг нэг чулуу нэмсээр байгаад сүр бараатай овоо болжээ.

Нөгөөдөр нь бас өнөө овоогоор дайрч буцах даа олз омогтой, баяртай, итгэлтэй явлаа. Мөрөөр нь орж бүтэн өдөр хөөцөлдсөний эцэст Жанибек гуай гунжин үнээний дайтай азарган чоно унагаж нэрээ хамгаалсан юм.

Хэд хоноод миний бие ахиад л унасан шорооноосоо тасран одлоо. “Салсан өдөр байхад уулзах өдөр бий” гэж Жанибек гуай хэлж билээ. Тийм үгэнд итгэж явах хэрэгтэй юм.

1971 оны VII- VIII сар.

Монгол хэлээр орчуулсан

1975 оны IX-X сар

"Аянгат цагийн тууж"-ийн төгсгөлийн үг

Орон улс яруу найрагчаа төрүүлж, яруу найрагч орон улсаа алдаршуулдаг. Аль ч орны түүхийн ботийг сөхөөд үзвэл ноёлогчдынх нь нэрийн хэлхээс, оршин суугчдынх нь нийгмийн үй мээн, оролцсон дайных нь дэс ду гаар харагдана, тэр орны газар зүйн тухай юу бичсэнийг уншаад үз, аль өргөрөг дээр оршихыг нь, ус голынх нь өргөн, уулс нурууных нь өндөр, бас амьтан, ургамлынх нь аймгийн тухай хэсэг бусаг юм байхаас хол хэтрэхгүй. Харь орны тухай шинжлэхүй ухааны хичнээн ч ном сэлт уншлаа гэсэн эцсийн эцэст чи нэгэн цогцост нэг дэх сүүхээгүй, нэгдлээ ч гэсэн ан цав нь харагдаж байдаг тийм дэл сул хэсгүүдийн урд зогсох вий.

Харин орон улсын төрүүлсэн ёстой яруу найрагчийн зохиолыг уншаад үзэж гэм, хүн зонх нь ааш зангийн онцлог, тэдний юунд баясч, юунд гутардгийг, үдэш шөнөөр орон гэртээ ямаршуу янзтай сууж, ирэх өдрийг хэрхэн хүлээдгийг, агаарынх нь амт, газрынх нь үнэрийг, голомтоос нь дэгдсэн утаа тэнгэр өөд хэрхэн зам татуулан оддогийг барим тавим олж мэднэ.

Яруу найрагч орон улсаа бүтээх нь: Хебрейн яруу найрагчид чамайг “Би ч гэсэн оюун санаанаасаа тэрсэлчих юм биш биз” гэж түгшин бодтол чинь Гетсеманы цэцэрлэгийн гүн рүү хөтөлнө. Хомерын Одиссей чамайг Эгийн тэнгисийн хөвөөнд өөрийнхөө үеийн хүмүүсийн дунд оруулна, Толс той чамайг энэ зууны босгон дээрх Орос орон, Москва, Петроград, Тула хавийн нутаг Ясная Ролянадаа аваа чина, Лакснессын Салка Валка, Ола фур Карасон чамайг Исланд орон той, Бальзак тэртээ нэгэн эриний Па ристай, Айтматов Киргизтэй, Гам затов Дагестантай танилцуулна. Түүн дээр одоо бас Монголыг бидэнд ойр туулах Чинагийн Галсан гэдэг нэгэн хүн гарч ирж байна. Алтайн уулс, Азийн тал нутгийн гэрч болох хувь тавилан түүнд оногджээ.

Яруу найрагчийн амьдрал дардан замаар өнгөрөх нь үгүй, тийм зам бай даг юм шиг хааяа санагдвал, тэр нь урьд юм уу хожим зориуд өнгөлж толийлгосон хүний амьдралын гадаад баримт сэлтийн хэлхээс төдий юм. Монгол улс үндэстний цөөнхийн төлөөлөгч Тува хөвгүүн Чинагийн Гал санд гадаадад очиж, сургуульд су ралцах бололцоо олгожээ. Тэрээр нэг ч биш хэд хэдэн орны аль нэгийг сон гож авах эрхтэй байжээ. Ирээдүйн оюу тан маань БНАГУ-д очиж суралцъя гэсэн бөгөөд заавал энэ орныг шилж авсан нь өөрийн учиртай. Түүнд кино сэлтээс мэдэж, үзэн яддаг болсон фашизмтай өчигдрийн түүх нь холбоотой, харин өнөөдөр бол зөвхөн фашизмыг бут цохиод зогсоогүй бас социализмыг байгуулж байгаа тэр улс сонирхолтой санагджээ. Энэ үедээ тэрээр германаар ганц ч үг мэдэхгүй байлаа.

Ингээд Чинагийн Галсан Лайпцигт иржээ. Шинэ орчиндоо яаж дассаныг өгүүллэгүүд нь хэлээд өгнө. Тэрээр нэгэн өдөр Бухенвальд-ыг үзсэнээс хойш, ахимаг насны хэнтэй ч нүүр учрах болгондоо “Тэнд болж өнгөрсөн хэрэг явдлыг хариуцалцах эздийн нэг нь энэ ч байж болох юм шүү” гэж бодон, ингэж бодсоноос болж заримдаа үл итгэх, энд тэнд хүнтэй маргах зэргээр өөртөө болон өрөөлд төвөг учруулж явсан удаатай. Тэрээр жишээлбэл өөрийнх нь бодлоор гэм тэн байж болох тэр хүмүүсийг өдөж дайрсан утгатай зохион бичлэг бич чихсэн хичээл дээр авчирдаг байс наа яваандаа тэдгээр нь богино өгүүл лэгийн төрхийг олж эхэлжээ. Монгол оюутан герман хэлээр зохиол бичиж эхэлсэн нь ийм учиртай.

Нийтээр хэлж занснаар Чинагийн Галсангийн аз нь таарчээ. Гэхдээ хү ний оюун санааны

хөгжилд ямар ямар хууль нөлөөлдгийг хэн маань л хэлж мэдэхсэн билээ? Учир нь тэрээр гэр бүл хоёр эрдэмтэнтэй нөхөрлөж тэдгээрийн нөмөрт тус улсын хот, хөдөө, Бах, Бетховен, Дюрер, Гранах зэрэг томчуултай болон германы ар дын үлгэр домогтой танилцжээ. Хожим автомашины осолд орж, хөл нь хугарахад мөнөөх хоёр түүнийг бүр гэртээ аваачиж суулгажээ. Ухаалаг эрдэмтдийн гэр бүл бол эрдэмд шамд сан залуу хүүгийн зүг зүг тийшээ өсөж төлжих цэцэрлэг нь чухамдаа мөн байлаа.

Чинагийн Галсантай яаж танилцсанаа мэдээлэх нь надад үлдэж байна. Энэ ч бас тийм жирийн нэг учрал байгаагүй юм. Тэрээр надад герман хэлээр бичсэн анхны өгүүллэг сэлтээ явуулжээ. Би түүнийг нь уншиж үзээд: “Харь нутгийн хүний амьдралыг сонирхдогийг минь ашиглах гэхдээ хаа холын монгол, тэр ч байтугай тува хүн болж үзэх заль бас нэгэнд нь төрөөдөхжээ. Бичсэн юмаа надаар уншуулж, миний саналыг дуулах гэсэн энэ сүрхий эр явж явж Ошатцын оюутан байхаас зайлахгүй” гэж Эвад дургүйцэн өгүүллээд тавьчихав.

Эхнэр маань өнөөдүүлийг уншаад: «Бичсэн эзэн нь хэн ч байсан, эндээс авьяас сэнгэнэж байна» гэлээ. Удсан ч үгүй Ч.Галсангийн өөр бусад зохиол, тайлбар сэлтгэй ирлээ. Дараа нь бид түүнтэй Лайпцигт уулзаж, суудаг айлаар нь хүртэл очиж үзсэн бөгөөд, хожим тэрээр Шульценхофт зохиолчийн амьдран суудаг тосгонд ирж хэд долоо хоног байхдаа ард минь зогчихоод мөрөн дээгүүр өнгийн “Есөн сарын мягмар гариг”-аа хэрхэн бичихийг минь харж, хариуд нь надад нутгийнхныхаа морь малдаа хэрхэн ханддагийг үзүүлдэг байлаа. Галсан манай цэцэрлэгийн бяцхан саравчинд унтаж, ажиллаж байсан бөгөөд, түүн дотор манай нилээд зохиолчид залуу зохиолч байх үедээ сууж байсан түүхтэй билээ.

Галсан германаар бараг харь аял гуугүй ярьдаг бөгөөд яруу найрагч гэдгээ юуны өмнө мэдэж байв. Тэр ч байтугай үүнийгээ тэр үед дэндүү мэдэрч байсан тул, бусдын анзаарч мэдээгүй, өөрт нь мэдэгдэж байгаа зүйлийг гадагш гаргах гэхдээ нэг хэсэгтээ ойр хавийнхнаа зовоох нь уран бүтээлч бүрийн тойрч гардаггүй, дайрч гардаг замын нэгэн хэсэг гэдгийг мэдэхгүй байсан бол бид түүнтэй түнжин үүрд тасрах байсан биз ээ. Галсан манай орноос бүрмөсөн буца хын урьд орой нь ч гэсэн бид сүр хий зөрөлдөж салж билээ. Тэрээр салал тын хэцүүг эрмэгхэн хэлсэн үгсийн ард нуухыг оролдсон ч, эсвэл бид зохиолоо ирээдүйд ч германаар бичнэ гэсэнд нь дэндүү эргэлзсэн ч байж болох юм.

Бидний эргэлзээ үндэсгүй байжээ: Улаанбаатарт очоод ч германаар бичсэн шинэ шинэ өгүүллэг бидэнд ирсэн бөгөөд санаа бодлоо герман хэлээр илэрхийлэх чадвар нь улам бүр өссөөр байлаа. “Ёстой л байгалиас заяасан авьяас гэдэг чинь энэ байх даа, суугаад л биччих юм, харин хаанаас аваад бичиж байгаагаа мэдэхгүй юм” гэж ярих дуртай хүмүүс байдаг. Тэгж яригсад бол энэ ч жорыг, тэр ч зааврыг харгалзан байж, зохиолынхоо гурилыг сүрхий нарийн найрлагаар зуурч ававч гараас нь талх биш, амсыя гэхэд амнаас уначих гээд байдаг жонхуу гардаг тийм мэрхүү л зохиолчид юм.

Галсан ч гэсэн Нөлөөнд автахыг тойрч гараагүй. Энэ нь юуны өмнө найрагчдын эгнээнд ороход (энд нээ рээ л давхар утгатай!) өөрт нь удаашраад байх шиг санагдсан тийм үед илэрч байв. Хямд чамирхлын мөр хөөх, бас заримдаа Хемингуэйчлэх хандлага ч гарч байв, гэвч тэр нь хоёр гурван өгүүллэгээс хэтэрч байсангүй. Тэрээр жишээлбэл Эрнест ахынх нь хүрэм зохихгүй гэдгийг өөрөө ч дороо мэдэрч байв. Италид, тэр ч атугай хэний ч үл мэдэх газар оронд болж байгаа үйл явдалтай өгүүллэг ч бичсэн удаатай, гэхдээ л төрсөн нутгийн

чинь хүн зон уул ус, ургамал амьтан, яруу найргийн гэрэл гэгээнд татан гаргаснаараа өөрийг нь ахин бүтээх найрагчаа хүлээж байна гэж сануулсан захидлын хэдэн үг залуу зохиолчид санаа авахад нь хангалттай байв.

Монгол эх орон, хүн ардынх нь тухай бичих замдаа нэгэнт ороод хэдэн жил болж байгаа Ч.Галсангийн заримдаа ч хүндэтгэн биширч, зарим даа ч хөмхий зуун бичсэн барим тавим дүрслэлтэй, яруу зохиолыг уншихад энэ оронд хүн алсаас хайртай болж, хүн ардыг нь гайхан бишрэхэд хүрнэ.

Чинагийн Галсангийн багшлах, ор чуулахын зэрэгцээгээр уран зохиол дээрээ биеийн алжаалыг умартан ажил ладгийг нь нотлоод өгөх бусад зохиол нь ч гэсэн заримдаа наанаа хэдий хайргүй хатуу юм шиг санагдавч, цаанаа заавал өөдрөг үзэлтэй, ардач байр сууринаас бичигдсэн онцлогтой юм. Эдгээр зохиолд эмээлийн минь ганзганд уяатай байгаа сарлагийн су ран аргамжнаас ханхалсаар байгаа хурц содон үнэр шингэсэн юм шиг. Тэр аргамжийг Галсангийн эцэг, ухаан тан мэргэдийн царайтай адуучин тува өвгөн надад явуулж билээ.

БНАГУ-ын төрийн таван

удаагийн шагналт зохиолч

Эрвин Штриттмат тер

1972

Баатрынхаа мөрөөр

/Зохиолчийн өчил/

Бичигдээд 15 жилийн хойно “Аянгат цагийн тууж” нэрээр монгол хэлнээ гарсан зохиолын минь эх нэр нь “Айнэ тувинишэ гэшихтэ” буюу “Тува тууж” билээ. Йоханнес Бобровский хэмээх славян нэртэй, литва гаралтай, герман хэлтэй зохиолчийн “Айнэ литауишэ гэшихтэ” /Литва домог/түүх/ нэртэй, хагас хуудас орчим хэмжээтэй бэсрэг өгүүллэгийг уншгал өөрийн нутаг усны тухайд ингээд хуучилбал надад ч хэлэх юм бий дээ гэсэн шүү бодол толгойд орж ирээд тэр даруй нөгөө гарчигийг тавьж авсан санагддаг. Ха рин дараа нь бичээд эхэлтэл миний бодсончлон аягатай цай хөрөхийн хооронд гараас гарчих уянгын бэсрэг ч биш, бүтэн юм уу хоёр, аягүй бол гурав дөрвөн хуудаснаас наашгүй, нэлээн сунжруу өгүүллэг болмоор бодогдоод дургүй хүрч, зүрх зориг ч бяцхан алдарч байсан. Гэхдээ өө рийгөө тайвшруулах арга хайн, за яахав, бяцхан сунавал ч сунаг, ан авд мордож байгаа тува эрийн л зураг гарна биз гэсхийн бичээд сууж байтал Жанибекийн нэр, царай зүс аяндаа тодроод ирж билээ.

Хорвоогоос буцаад тухайн үедээ 14 жил өнгөрч байсан тэр өвгөн өөрийнхөө тухай бичүүлэхээр миний ухаан бодол дотор ээлжээ хүлээгээд л явж байжээ. Тийм ээ, түүний тухай би эрт, орой хэзээ боловч нэгэн цагт заавал бичих л байсан юм. Яагаад гэвэл тэрээр янхир том биетэй, төө цагаан сахалтайгийн хувьд бүр гадаад төрхөөрөө л харсан бүгдийн нүдэнд өртөхөөр нэгэн байжээ. Чих бяцхан хатуу, архинд яльгүй дуртай, өвөл зунгүй хөл дүүжлэх ганц хар морьтой, тэр нь бусад морьд дундаас мөн л сондгойрч харагдах том биетэй, хатируулбал хатираатай, цогиулбал цогиотой, гэтэл номхон гэж тоймгүй. Чухам тийм болоод ч тэр биз, гэрт эзэн нь лонх юм сөгнүүлээд сууж байхад гадаад хүүхдүүд морийг нь уначихсан хурга, тугал дөхүүлээд ирэх нэрээр хийсгэж л явна. Ингэж байтал хааяа өвгөнийг гараад ирвэл айхын хэрэг байхгүй, загнахын оронд харин ч “Өвөөгийн чинь морь хурдан байна уу?” гэж асуугаад “Тийм байна аа” гэвэл “За тийм бол бид хоёр энэ жилдээ бас л ажрахгүй юм байна” гэснээ инээх аядана. Тэгэхээр харсан бүгдийн нүдэнд өртөөд ч зогсохгүй, бас учирсан бүгдийн сэтгэлд хадагдахаар л нэгэн. Түүн дээр анх удаа анчид дагаж алсын авд мордохдоо тэр бууралтай нэгэн галд багтаж билээ. Гэхдээ энэ Жанибекийн тухай миний заавал бичих байсан шалтгаан хараахан биш ээ. Зайлбаргүй тэр шалтгаан нь гэвэл, Тэрээр Баянакийн эцэг юм. Тэгэхдээ хэн хүний л адил өдөржин дош сахиж, арай гэж гарч ирсэн тарвагыг заримдаа алдаж бууддаг, авахын цагт харин хотил ч байсан хөөрч баярладаг тэр өвгөнийг өнөө цуутай Баянакийн эцэг гэж анх дуулахдаа гайхаж хоцорсноо миний бие хэлэх ёстой. Харин дараа нь дуусашгүй яриагий нь чагнан чагнасаар олон үдшийг өнгөрүүлж, ав аянаас буцахын цагт Баянакийн эцэг бол ийм л хүн байх ёстой, өөр хэн ч байж чадахгүй гэж боддог болсон байж билээ.

Баянак гэж хэн байв? 1945 онд Там сагбулагт цэргийн алба хааж байгаад ялихгүй эндэгдлээс болж хүнд ялд унахын даваан дээр оргосон, нутагтаа хүрч очтол баригдаж, хойшоо хүргэг дэх замдаа ахин оргосон, тэгээд буцаж очиж уул хаданд хоргодсоор хоёр өвлийг даваад гурав дахь жилийн орой намар буудуулсан нэгэн.

Тэр цагт түүнийг эх орноосоо ур вагч, онц аюултай гэмт хэрэгтэн гэж үздэг байж. Тангарагт цэргийн алба наас оргосон, бас биендээ зэвсэг авч явсан болохлоор арга ч үгүй биз. Түүнийг баривчлахад оролцоогүй буюу хойрго байдал гаргасны учир хэд хэдэн хүн шоронд хүртэл

орсон юм гэдэг. Гэхдээ ухаан орж, ухамсар суусан цагаасаа түүнийг муугаар хэлж байсан хүнийг би л лав дуулаагүй. Эр энддэг гэгчээр санамсаргүй зүйлээс алдаж, цагаатгахын аргагүй алдас үйл дэвч хэнд ч гэм хийлгүй, замаараа явж байгаад цэл залуу насандаа амь алдсан хүний ганц хүү гэсэн маягийн өрөвдөж хайрласан үгийг бол харин олонтаа сонссон.

Хожим оюутан, сэхээтэн болж 1966, 1967, 1969 оны зун амралтаараа герман эрдэмтдийн түлхээс, дэмжлэгээр ар дын аман зохиол цуглуулж явахдаа Баянакийн тухай домог гэмээр яриа, олон бадаг дуу үүссэнтэй тааралдсан. Гэхдээ түүний талаарх тухайн үеийн албан ёсны үнэлгээнд ямар нэгэн өөрчлөлт гараагүйг, гарах ч үндэсгүйг бас ойлгосон.

Тэрхүү домог, дууны цаана байгаа түүхэн хүн оргож босч явахдаа уудам монгол нутгийн хаана л бол хаана шингэж болох байсан боловч хэзээд унасан газар, угаасан усаа тэмцэн хүрч ирдэг байсан, бас зэвсэглэсэн эрлийнхэнд тэр олон сар, жил хөөг дөж, эцэстээ алуулж дуусахдаа тэрээр адилхан зэвсэгтэй мөртлөө хэнд ч хор хүргээгүй ийм хоёр учир шалтгааны үүднээс надад гайхалтай, тэр ч бүү хэл биширмээр санагддаг байлаа.

Гэтэл одоо эцгийнх нь нэр, дүр үзгийн минь үзүүрээс аяндаа тодроод ирсний цаана тэрээр байж байсан нь эргэлзээгүй. Тэгээд ч би эцэг, хүү хоёрыг албаны ам цагаан цаасан дээр бичигдэж үлдсэнээр нь биш, ард түмний сэтгэл зүрхэнд хадагдаж үлдсэнээр нь зохиолд оруулж, хой чийн түүхийн өмнө тэднийг цагаатгах зорилтыг өмнөө тавьсан юм. Эцгийн хэлмэгдлийн тухайд энд цу хасхан дурдаад авахад, Ганц хүү нь хорвоод төрсөн тэр жил бас түүхнээ мэндэлсэн засаг төрд дөрвөн суман тувачууд дотроос хамгийн түрүүнд зүрх сэтгэлээ өгч, намд элссэн тэрээр хожим хүүгээсээ болж өнөө намаасаа хөөгджээ. Намаас хөөгдөх гэгч юу болохыг хойч үеийнхэн бүрэн утгаар нь төсөөлөн мэдэхгүй байж болно, бид бол харин мэднэ, одоохондоо мартаагүй байна. Хүмүүн төрлийг олж төрсөн ховор азтай аавын хүү, ээжийн охин нам төр, нийгэм-бүхний өмнө золбин нохой болно гэсэн үг!

Тийнхүү эцэг, хүү хоёрын эмгэнэлт туужийг бүтээхдээ уран сайхны шаардлагын үүднээс би зарим зүйлийг өөрчилсөн. Амьдралын үнэн гэвэл Суяш, Доёбуу хоёрын аль алиных нь эх дүр байсан ч, хэн хэн нь өөр нэртэй байсан, бас тэд хоорондоо сууж байгаагүй, тэгэхээр Баянак Доёбуутай төрлийн ямар нэгэн холбоо байхгүй.

Баянакийг эцэг нь алаагүй. Шөнийн харанхуйд олон хүн ойрхноос зэрэг зэрэг буудах үеэр нэг л сум туссан, тэгэхээр алуурч нь хэн бэ? гэдэг нь чухамдаа тодорхойгүй, гэтэл бараг бүх хүн тухайн үед “Тэр бол миний буунаас гарсан сум!” гэж андгайлах нь холгүй байснаа, сүүлд болохлоор “Миний л сум лав биш” гэдэг болжээ - цаг үе ээ гэж!

Гумайн эх дүр байсан, нэрийг нь ялимгүй өөрчилсөн, хань нөхөртэй, өнөр өтгөн айлын эзэгтэй болж, овоо л амьдарч явсан, овоо ч насалсан. Баянак Хара Хоовд тэднийд биш, өөр газар, өөр айлд хонож байгаад осолдсон.

Үзэг салгалгүй бичжээ. Сэхээ завгүй ажилласаар зохиолоо дуусгаад санахад хоёр долоо хоног өнгөрчихсэн, өөрөө би турж туйлдчихсан байж билээ. Гар нооргоо машиндаад өнгөн хувийг Эрвин Штриттматтерт явуулаад 10-аад хоног өнгөртөл баяр хүргэсэн цахил гаан утас ирсэн юм.

БНАГУ-ын 1972 оны номын төлөв лөгөөнд уг тууж, бусад зарим зохио лоос бүрдсэн миний анхны номыг “Фольк унд Вельт” хэвлэлийн газар хэвлэхээр оруулжээ. Гэтэл манай тал зөвшөөрсөнгүй. Ингэх олон шалтгаан байсан юм байх. Тэдгээрээс хамгийн гол нь Төрийн шагналтангуудын зохиол орчуулагдан гараагүй байхад эхлэн бичигчийнхийг гаргавал монголын уран зохиолын талаар герман уншигчдад буруу төсөөлөл өгч бол зошгүй гэнэ. Цаашилбал ахмад зохиолч “герман” Наваан-Юндэн гуай уншиж үзээд “зохиол огт биш юм” гэжээ, “зохих албаны шугамаар” няг талсан нэгэн эргэлзээтэй 240 үг, өгүүлбэр жагсаажээ, тэдгээрийн эхэнд зохиолын гарчиг орсон нь “Тува” гэ дэг үгийн ард улаан харандаагаар гурван давхар асуултын тэмдэг тавьж, “тууж” гэдэг үгийг “түүх” болгон ойлгожээ. Хожим олон жилийн дараа монголоор арай гэж хэвлэгдэхэд нь ч эх нэрээр нь гаргах гээд дийлээгүй, аргаа барахдаа “Аянгат цагийн тууж” болгосон билээ.

Уг тууж энэ завсар хэд хэдэн хэлнээ орчуулагдсан сураг бий, гэхдээ өнөө хэр алий нь ч олж хараагүй учраас тэр талаар хэлчих тоймтой юм надад алга. Харин тийм сураг дуулдах бүрийд сэтгэлд заавал сэрдэг нэгэн бодлыг энд хэлбэл, Аливаа бүтээл бүтээгчийнхээ гараас нэгэнт алдуурсан хойно голомт юугаа орхин гарсан хүний үр хүүхэд эх эцэгтээ захирагддаггүйн нэгэн адил эзэндээ захирагдах нь үгүй, биеэ даан өөрийн амьдралын үл үзэгдэх зам зөргөөр хаашаа ч явж, юунд ч орчихож магадгүй бололтой.

Энэ хүртэл би оршил маягийн юм өгүүллээ. Түүнийг ганцхан өгүүлбэрт багтааж ч болох л байсан. Гэхдээ уг туужийг бичсэн түүх, түүний үйл яв дал, ялангуяа баатруудтай холбоотой зүсэн бүрийн асуултыг уншигчдаас надад тавьдгийг санаад нэгэнт далим боломж гарсных, цөөн зарим зүйлийг хэлчихье гэж шийдлээ.

Эл өчлийг бичих болсны учир гэвэл, туужаар сэдэвлэн кино бүтээ хээр өндөр Алтайдаа ирээд байна. Баянакийн амь хоргодон өвөр, хуниа санд нь нуугдаж явсан хадан уулс зүг зүгт дүнхийнэ. Баянактай тоглож, өвөр түрийдээ өссөн, Баянакт хоол хүнс залгуулж байсан, Баянакийг бараа дан ан авын замд орсон, тэрчлэн Жанибекийг үзсэн, яриагий нь дуул сан, тэр ч бүү хэл амьдралынх нь сүүлийн хагаст түүнийг тойлж хүн дэлж явсан хүмүүс өвгөчүүл, эмгэчүүл болчихсон эргэн тойронд эрвийнэ. Хүн бүрт хуучлах өөрийн гэсэн дур самж бий ажээ. Тэнд дуулсан бүг дийгээ цаасанд буулгая гэхэд дахиа нэгэн тууж байтугай романд ч багтамгүй. Олонхийн яриа миний дуул сантай, бас миний үнэлгээтэй таарах шинжтэй. Цоо шинэ юм ч их, бас өмнө дуулсныг няцаах зүйл ч мэр сэр. Тийнхүү дуулсныхаа заримаас сонирхуулья.

Баянак 1918 юм уу 1919 онд төрсөн, морин жилтэй, байсан бол одоо 73-ных нь жил орж байх учиртай ажээ. Эхээс эрт өнчрөвч Жанибек ганц хүүгээ хүлхэх нь холгүй хайрлан өсгөжээ. Тэрээр эцгийгээ дуурайсан өндөр нуруутай, өргөн цээжтэй, бүргэд хамартай, хүрэн царайтай, үс нь хонгордуу туяатай, нөхөрсөг, цагаан, заримдаа ч аархуу гэмээр, маш хэлэмгий, тува, хасаг, монгол гурван хэлийг, тэрчлэн монгол бичгийг гаргуун эзэмшсэн нэгэн байжээ.

Туужид Дака нэрээр гардаг Даг вынд олон хоноцтой байхад нь дээ рээс нь ирж хоножээ. Хоймроор дөр вөн залуугийн голд нь хэвтэж байхдаа гараа алдлан тэдний цээжин дээгүүр дараад “Алив та нар босоод ир дээ!” гэхэд цаадуул нь яаж зүтгээд өндийж чадсангүй гэнэ. Тэгэхэд Баянакихэд сэтгэл хангалуун инээж “Арван эр ирэхэд би лав л дийлдэхгүй” гэхэд

“Иш чи минь, орох оронгүй, оочих аягагүй, амь наана, там цаана гэж яваад юу нь ч том ам гардаг юм бэ!” гэж гэрийн эзэгтэйд аашлуулж байжээ. Удал ч үгүй мөнөөх Дагва, Хөх хочтой Шынык, Урт хөл хочтой Дүгүр нарын гурван хүн Баянакийг барихаар цай ууж суухад нь гэндүүлэн дайрч үзээд золтой л бяцлуулчихсангүй, дээд газ раас даалгавар хүлээснээ хэлж гуйж залбирч байж мэнд салжээ. Түүний хариуд Баянак Дагвын цэргээс ирэхэд нь оёсон цагаан хурган дотортой хөх чисчүү дээлийг өмсөж, маузер буугий нь үүрээд гарчээ.

Тэмээн хүзүүний хавцалд түүнийг нэгэнт бүслэн авчээ. Гэтэл гэнэт өндөр дээрээс чулуу нураагаад унах нь тэр. Тэвдэж балмагдсан эрлийнхэнд тарж зугадан амь гарах арга бодохоос өөр зам үлдсэнгүй. Нэг сэхээ орж ирээд харвал өнөөх чинь өндрөөс харван бууж, Ховдын голын мөсөн дээгүүр гүйсээр гараад нөгөө талын эгц уулын нуранги асга өөд дөрвөн хөллөн самардаж маажсаар авирч байх нь тэр. Аймгийн хэлстийн төлөөлөгч Имамбай цаад хад руу нь чиглүүлж хэдэнтээ буудуулжээ. Зэр зэвсэгтэй тэр олон хүн огт буу дуугаргалгүй байсаар алдчихлаа гэхэд толгой дээр нь буух зэм улам хүндрэх байсан биз.

Гэнэт Баянак биеэ эзэмдэж чадахаа болив бололтой, эргэж зогсоод “Би хэнд ч муу юм хийгээгүй. Тува, хасаг та нарт бол бүр ч үгүй. Амьд л явах гэсэн нэг муу өнчин хүүг заавал алж дуусах гээд байгаа юм бол ал л даа!” гэж тува, хасаг хоёр хэлээр хашгирчээ. Тэгснээ нэг бяцхан дөрөлж дээр гарч суугаад гутлаа тайлж, шинээр ороож аваад хад асга өөд авирсаар арилаад өгчээ. “Муу юм хийгээгүй... та нарт бол бүр ч үгүй” гэдгийн тухайд: Заримдаа өглөө босоод ирэхэд хүзүүнээс нь сийлбэртэй, бичигтэй пайз зүүсэн хурга хотон дотор, эсвэл тугал зэлэн дээр байж байна. Бас хөрзөнгөө ховхлохоор өвөлжөөнд очвол аль хэ дийнээ ховхлоод бүр чулуун хороон дээгүүр үелээд хураачихсан байж байна. Тэгтэл нэгийн зэрэг хүнд муу юм бас хийсэн ч юм шиг: Пагвын цоохор морийг бахардуулж алаад сэтэртэй бор морийг унаж яваад осолджээ. Гэхдээ олон хүний ярих нь, цаадах нь түүнийг заавал бариулах, тэр ч бүү хэл бүр алуулах гэж хүүхэд залууст ацаглах хүртлэхийг хийснээс түүнтэй өстөн болжээ.

Тэмээн хүзүүний хавцлын урагшаа харсан эгц ханан хадыг нэгжсээр яваад сайн газарчны буянд Баянакийн агуйг олж илрүүллээ. Тэрээр хэд хэдэн агуйтай байсан, цаашаа харсан талд бүргэд үүрлэх халил дунд байдаг гол агуйг мэдэх, мэдлээ ч түүнд хүрэх хүн одоо байхгүй гэнэ. Бидний олж очсон агуй бол өвлийн өдөр түүний нарлаж, гол нь харуулд суудаг, орчин үеийн хэлээр бол “Манаачийн шовгор” нь ажээ. Бүтэн алхам голчтой, бүтэн хагас алхам өндөр тэр агуйд биерхүү Баянак бөгтийж орж гарч, зовж л эргэж байсан байж таарна. Агуйн дотроос хэд хэдэн зүйлийг оллоо. Доод үзүүртээ мухар сөөм голч бүхий булцуутай, дээшлэх тусам шувтан, дөрвөн төө урт иштэй, суран сагалдрага нь тасарчихсан хусан бороохой агуйны мухарт байлаа. Буу дуугаргахгүй, сум гарздахгүй гэсэн, бас сүрэг чононд ээрэгдэх зэрэг аминд тулсан үед хэрэглэхээр бэлдсэн зэвсэг нь биз ээ. Үнстэй шороон дотроос бас нэг хуруу зузаан, гурван хуруу өргөн, таван хуруу урт модон дээр урласан нэн сонин сийлбэр оллоо. Тал бүрийн сийлбэр өөр өөр юм. Ур дүйтэй хүн байжээ. Хамгийн сонирхолтой, эх орноосоо урвасан гэгдэх Баянакийг дур мэдэн цагаатгасан миний хувьд баярлууштай нь гэвэл хээ, угалзнаас гадна МОНГОЛ АРД УЛС хэмээн шинэ бичгээр чадварлаг сийлжээ. Галт бууны хараан дор хөөгдөж зэрлэгшиж явсан амьтан өөрийг бус, чухам тэр гурван үгийг эрхэмлэн урлаж суусны тухайд аливаа тайлбар илүүц болох биз ээ. Навтас болсон нэгэн хувцас үнс шороон дундаас гарсан нь тэр үеийн эмэгтэйчүүдийн нударгатай дээл ажээ. Тэрчлэн цагаан нэхий өрөөсөн дэгтий, шүдэнзний хайрцгийн шур гуулга олдов. Бас бодын чөмөгний хэдэн яс

Тэнд хэвтэх нь бодоод байхад Баянактай холбоотой байхын аргагүй ажээ. Өндөр Алтайн нар, салхин дор 43 жил хэвтсэн яс нэгд, хувхайрч цайрахгүй байж чадахгүй, хоёрт, хүн тэдгээрийг таших нь зайлшгүй. Тэгвэл элсэн шаргал өнгөтэй тэр хэдэн яс бүв бүтнээрээ, зарим нь бүр үеэрээ хэлхээтэй хэвтэх юм. Олон жилийн сүүлд агуйд чоно үүрлэжээ гэж үзэж болмоор.

Баянакийн тийнхүү амьдарч явсан зам мөрийг хөөсөөр дууссан газар нь хүрч очив.

1947 оны орой намар олондоо “багш” алдартай Халтар гэдэг айлд хо нож байтал эрлийнхэн мэдчихээд бүслэн авчээ. Дээлээ нөмрөн буугаа барьсан чигээр гэрээс гүйж гартал зүг зүгт л нижигнээд явчихжээ. Үх дэл хүүрийг хэдэн алхам цааш нь чи рээд гутал хувцастай нь чулуугаар да руулжээ. Чингэхдээ дээрээс нь дээ лээр бүтээсэн бөгөөд тэр нь мө нөөх хурган дотортой хөх чисчүү дээл ажээ. Дагва туужид Дака нэрээр гардаг бөгөөд энэ нь ч түүний жинхэнэ тува нэр нь юм. Тэрээр Сэлэнгийн Орхонтуулд цагаачлан ирж аж төрж байгаад хэдхэн сарын өмнө нас баржээ. Туужийг бичсэнээс хойно миний бие тэр хүнтэй уулзаж, оргодол барих гэж хөглөсөн тухай нь яриулсан юм. “Хөөрхий минь, сайхан ч эр, сайн ч хүн байсан. Яг алах байх гэж бодсон чинь амьд үлдээчихсэн. Тэр муу дээл яахав. Түүний өмнө би буруутай, түүнийг би бүр буудах даалгавартай, гэрийн үүдээр өнгөрч явахад нь буу шагайж хэвтсэн - нүд бүрэлзэж, гар салгалаад болдоггүй юм чинь л тэр байлаа” гэж байж билээ.

Хөлд нь миний аавд зориулан миний ээжийн оёсон цоо шинэ хүрэн хөмөн гутал үлджээ. Түүнийг уллаад дөнгөж гүйцэж байтал манайд Баянак орж ирээд “Гутлын ул цоорчихоод хөл хөрч явна. Гутлаа уллуулж автал ахын гутлыг өмсөж байгаад аваад ирье, эгч минь гэсэнд ээж “Тэг ээ” л гэлгүй хаачихав. Түүний ердөө дараахан дээрх явдал болсон тул Баянак ээжид өгсөн амандаа хүрч чадсангүй.

1990 оны Ү сарын 16-нд бид Бая накийн осолдсон бууцан дээр очлоо. Уулын давчуу амны эхэнд нөмөр сайхан газар юм. Баруун дор Ховд гол харгиатан шуугиж, хойд, зүүн талаас хүрээ хад арсайн хүрээлээд урдаас эгц хүүш тулсныг харахад амьд явахын хүслэн болсон хүний хүүгийн зам энд арга ч үгүй мухарджээ гэмээр. Өндрийн элс, чулуу гэрийн буурийг дээрээс нь даран дарсаар сорви гэмээр ором үлджээ. Чулуун хороог чулуу “гүүплэгчид” дээрээс нь амарчлан ачсаар мөн л ором төдий дөрвөлжин үлдсэн харагдана. Хэдхэн алхмын цаадах хадны ёроол дахь хэдэн хавтгай хөх чулууг хожим хүн авчирч зориуд овоолсон нь илт ч учрыг мэдэхгүй нэгэнд бол тэнд хүний ганц хүү, туужийн баатар, зүс үзээгүй үеийнхэнд домог болон яригдсаар, мөнхөд залуугаараа үлдэх хувьтай сайн эр дараастай хэвтээ гэж мэдэхийн арга даанч алга. Гэхдээ бидний үеийнхэн, олон зууны турш монголын төрд данстай, түмэнд зартай явсан Дөрвөн сумын тувачуулаас энэ нүцгэн уулстайгаа зууралдсаар үлдсэн сүүлчийн долоон зуун гучин долоон хүний ахмад үе нь тэрхэн зурвас үеийнхэн түүхийг одоохондоо мэдэх юм даа.

Баянакийг булшлаад 43 жил өнгөр чээ. Гэхдээ нэгэнт үхсэн хүний хувьд бол 4 хоног ч, 40 жил ч, 4 зуун ч адилхан биз. Яагаад гэвэл, үхэгсдийн өмнө бүх юм, түүний дотор бас цаг хугацаа учир утгаа алддаг, тэгэхээр үхсэн нэгнийг цагаатгах буюу буруутгах гэгч үлдсэн хүн мөнөөх өөрийгөө л бодож, чу хам даа өөрийгөө хуурсан хэрэг гэж би боддог.

Бидний болон хойч үеийнхний тийнхүү өөрийгөө бодох ухааны үүд нээс ч гэсэн энэ чулуун булш үүрд ингэж хөсрий мартагдан хэвтэж бо ломгүй санагдана. Өчигдрийн өдөр хүртэл

Улаан номонд орж ч чадалгүй явсаар мөхөх тавилантай юм шиг санагдаж байсан, өнөөдөр харин хүн төрөлхтний өнөр их бүлийн давжаа хан, даруухан ч гэсэн нэгэн гишүүний хувьд үеийн үед байсаар байх хувь тай гэж бодогдох болсон тува түм ний минь үр сад энд алгын чинээ дурсгалын самбар босгочих, эсвэл бүр дээдсийнхээ үед эндэж гэнэдсэн нэгнийгээ золбин нохой, галзуу чоно адил хаданд үүрд даруулж хаяхыг тэвчилгүйгээр ёс төртэй оршуулчих, тэгснээрээ хэзээ нэгэн цагт оргож босч явсаар алуулсан оргодлыг биш гэхэд бусдын л адил түүхийн бартаат замд бүдэрч сөхөрч явсан үндэс угсаагаа доромжлолоос аврах ухааныг олох ч юм билүү?...

Булшнаас хэдэн аргамжийн зайнд торойх чулуун хөшөөг хэзээ, хэн, хэнд зориулж босгосныг одоо мэдэхийн арга алга. Энэхэн эгшинд тэрээр нут гийн минь ах, туужийн минь баатарт зориулсан ч юм шиг. Магадгүй, хэзээ нэгэн цагт, хэн нэг нь түүнийг босгохдоо, бас хойч үеийнхэнд нөмөр бараа, чиг баримжаа болоосой гэж бодсон ч юм билүү, хэн мэдлээ...

1990.05.18.



ГАДААДЫН ХЭВЛЭЛД ЧИНАГИЙН ГАЛСАНГИЙН ТУХАЙ

Орон улс яруу найрагчаа төрүүлж, яруу найрагч орон улсаа алдаршуулдаг. Хомериин Одиссей биднийг Эгийн тэнгисийн хөвөөнд аваачиж, өөрийнхөө үеийн хүмүүсийн дунд оруулдаг. Толстой ХХ зууны босгон дээрх Орос орон, Москва, Петроград, Тула хавийн нутаг, Ясная Полянадаа аваачдаг. Лакнесын САЛКА ВАЛКА, ОЛАФУР КАРАСОН Исланд оронтой, Бальзак тэртэй нэгэн эрийний Паристай, Айтматов Киргизтэй, Гамзатов Дагестантай танилцуулсан билээ. Түүн дээр одоо бас Алтайг бидэнд ойртуулах Чинагийн Галсан гэгч нэгэн гарч ирж байна □

БНАГУ-ын Төрийн таван удаагийн шагналт зохиолч Эрвин Штригматтер □Аянгат цагийн тууж□ номд бичсэн төгсгөл үгнээс. Фольк унд Вельт хэвлэлийн газар.

Берлин, 1981 он.

Table of Contents

[Өмнөтгөл](#)

[Бүтээлийн хос морьтон](#)

[Аянгат цагийн тууж](#)

["Аянгат цагийн тууж"-ийн төгсгөлийн үг](#)

[Баатрынхаа мөрөөр](#)